**ОРХОН АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРААС ХЭРЭГЖҮҮЛСЭН, ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ТӨВ, ОРОН НУТГИЙН ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГАД ХАМААРАХ 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2016.12.14 Эрдэнэт

1 Удирдах ажилтны манлайллыг дээшлүүлж, алба хаагчид ажлын байрны зорилго, зорилтыг хангаж ажиллах.
2 Байгууллагын соёл, алба хаагчдын сахилга, ёс зүй, албаны бэлэн байдлыг сайжруулах.
3 Сургалтын чанар, үр дүнг дээшлүүлэх.

| Хөтөлбөр | Дугаар | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Биелэлт | Хувь | Оноо |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| **Нэг "Цагдаагийн алба хаагчийн харилцааны соелыг дэзшлүүлэх гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр. арга хэмжээ** | | | | | |
| 1.1 Алба хаагчдын сахилга, ёс зүй, ажлын хариуцлагыг дээшлүүлэх талаар | 1 | 1.1.2 2016 онд гэмт хэрэг болон сахилга, ёс зүйн байдалд дүгнэлт өгч, гаргасан шалтгаан нөхцлийг судлан, алба хаагчдад зөвлөмж хүргүүлж, үр дүнг тооцох. | 2015 онд эрүүгийн 2 гэмт хэрэгт 2 алба хаагч холбогдон шалгагдаж байсан бол 2016 оны мөн үеийн байдлаар 3 эрүүгийн гэмт хэрэгт 3 алба хаагч холбогдон шалгагдсан нь урьд оны мөн үеэс 1 хэрэг буюу 33.4 хувь өссөн байна.<br>2015 он тус Цагдаагийн газраас 23 алба хаагч сахилгын зөрчил үйлдэж байсан бол энэ оны мөн үед 25 алба хаагч сахилгын зөрчил гаргаж, 2 алба хаагч буюу 8.0 хувь өссөн байна. Нийт сахилгын зөрчил гаргасан алба хаагчаас 16 буюу 64.0 хувь нь офицер, 9 буюу 36.0 хувь нь ахлагч байгаа нь урьд оны мөн үетэй харьцуулахад зөрчил гаргасан офицер 2 буюу 12.5 хувь өсч, зөрчил гаргасан ахлагч алба хаагчийн тоо урьд оны мөн үеэс 1 буюу 10 хувь буурсанд байна.<br>Сахилгын зөрчлийн 17 буюу 68.0 хувь нь ажлын хариуцлага алдаж, цагдаагийн алба хаагчийн ёс зүй зөрчсөн, 2 буюу 8.0 хувь нь архидан согтуурсан, 5 буюу 20.0 хувь нь Эрүүгийн байцаан шийтгэх хууль зөрчиж, прокурорын шаардлага хүлээн авсан, 1 буюу 4.0 хувь нь цагдаагийн албаны үнэмлэх гээгдүүлсэн зөрчил тус тус эзэлж байна.<br>Зөрчлийн хэлбэрийг урьд оны мөн үетэй харьцуулбал, ажлын хариуцлага алдаж, ёс зүй зөрчсөн зөрчил 6 буюу 35,3 хувь өсч, архидан согтуурсан зөрчил 2 буюу 2 дахин, цагдаагийн албаны үнэмлэх гээгдүүлсэн зөрчил 2 буюу 2 дахин тус тус буурч, Эрүүгийн байцаан шийтгэх хууль зөрчиж, прокурорын шаардлага авсан зөрчил урьд оны ижил түвшинд байна.<br>Үйлдэгдсэн зөрчлийн 11 буюу 44.0 хувийг дотоодын хяналтаар, 14 буюу 54.0 хувийг гадны /иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол мэдээлэл/ хяналтаар тус тус илрүүлсэн байна. | 90% | 4,5 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Сахилгын шийтгэлийн төрлийг авч үзвэл 5 буюу 20.0 хувь нь цагдаагийн албанд нэг жилийн хугацаагаар эргэж орох эрхгүйгээр халах, 16 буюу 64.0 хувь албан тушаалын цалинг 1-6 сарын хугацаагаар 20 хувь хасах, 4 буюу 16.0 хувь сануулах сахилгын шийтгэл байна.<br>Үүнээс 23 буюу 92.0 хувийг тус Цагдаагийн газрын даргын тушаалаар, 2 буюу 8.0 хувийг Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар сахилгын шийтгэл тус тус оногдуулсан байна.<br>Çºð÷èë ãàðãàñàí áàéäëûã òàñàã, àëáàäààð íü àâ÷ ¿çâýë: Нийтийн хэв журам хамгаалах тасаг 6 /офицер 3, цагдаа 3/, “Эрдэнэт үйлдвэр” ХХК дахь Гэрээт цагдаагийн хэлтэс 8 /офицер 4, цагдаа ахлагч 4/, Хэрэг á¿ðòãýõ, ìºðäºí áàéöààõ òàñàã 6 /îôèöåð 6/, Ýð¿¿ãèéí öàãäààãèéí òàñàã 1 /офицер 1/, Төлөвлөлт, зохион байгуулалтын тасаг 1 /1 офицер/, Олон нийтийн аюулгүй байдлыг хангах төсөвт тасаг 3 /1 офицер, ахлагч 2/ алба хаагч тус тус сахилгын зөрчил үйлдэж, Замын цагдаагийн тасгийн алба хаагчдаас сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй ажиллав.<br>Сахилгын зөвлөгөөнийг улирал бүр хийж, түүнээс гаргасан санал, хүсэлтийн дагуу хамт олны эерэг уур амьсгалыг бүрдүүлэх, тэдний мэдлэгийн хүрээг тэлэх зорилгоор соён гэгээрүүлэх ажлын хүрээнд, сургалтыг 7 хоног бүрийн нэг өдөр зохион байгуулж, Цагдаагийн газрын удирдлагаас зааварчилга, зөвлөмжийг нийт алба хаагч нарт хүргүүлж ажилласан.<br>Цагдаагийн газрын 40 жилийн ойг угтаж “Сахилга, ёс зүйн зөрчил дутагдалгүй хамт олон болох” аян тасаг, хамт олны дунд 2 үе шаттайгаар явагдаж, аяны хүрээнд соён гэгээрүүлэх чиглэлээр олон төрлийн арга хэмжээ зохион байгуулсан. | | |
| | 2 | 1.1.6 Цагдаагиин газар, алба хаагчдын аюулгүй байдлыг хангах ажлыг эрчимжүүлж, харуул, хамгаалалтыг чангатгах, дохиолол, телекамерын системд холбогдох чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх. | Цагдаагийн байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах 2016 төлөвлөгөөг хэрэгжүүлэх чиглэлээр тус газраас 2016 онд хийх ажлын төлөвлөгөөг гарган газрын даргаар батлуулж, Цагдаагийн газрын дотоод аюулгүй байдлыг хангах орон тооны бус ажлын хэсгийг Цагдаагийн газрын даргын 2015 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн Б/06 дугаар тушаалаар шинэчлэн байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Дэд бөгөөд Эрүүгийн цагдаагийн тасгийн дарга, нарийн бичгийн даргаар эдийн засгийн ахлах төлөөлөгчийг томилон ажиллуулж байна.<br>Байгууллагын нууцтай танилцах эрх бүхий алба хаагчдаас “Төрийн нууц хадгалах журам”-ын дагуу нууц хадгалах баталгаа авч, Цагдаагийн байгууллагын гүйцэтгэх ажлын сүлжээний аюулгүй байдлыг хангах талаар өгсөн үүрэг, албан даалгаврыг алба хаагчдад танилцуулж, сургалт зохион явуулсан. Алба хаагчдын аюулгүй байдлыг хангах чиглэлээр Цагдаагийн ерөнхий газрын дарга, дэд дарга, Гэмт хэрэгтэй тэмцэх албаны дарга, Цагдаагийн газрын даргаас өгсөн үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр алба хаагчдад сургалт зохион, албан үүрэг | 90% | 4,5 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | гүйцэтгэх хугацаанд аюулгүй байдлаа хангаж ажиллах, үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын сонор сэрэмж, аюулгүй байдал, сахилга хариуцлагыг тогтмол шалган, илэрсэн зөрчил дутагдлыг цаг тухай бүрт нь арилгуулах, байгууллагын аюулгүй байдлыг хангаж ажиллах талаар газрын дарга болон тасгийн даргаас алба хаагчдад үүрэг чиглэл, зааварчилга өгч, биелэлт, үр дүнг тухай бүр тооцож ажилласан.<br>Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, хангамжийн газрын Хангалт үйлчилгээний төвөөс хувцасны хангалтыг татаж, нийт алба хаагчдад зуны хувцас, мөрдөс, агсамж, өвлийн хувцасны хангалтанд хамрагдаагүй 42 алба хаагчид өвлийн хувцас, хагас түрийтэй гутал 38, өвлийн малгай 68 ширхэгийг алба хаагчдад тус тус олгосон байна.<br>Объектын харуул хамгаалалт, хяналтын нэгдсэн системийг шинэчлэн зохион байгуулах, ажлын хүрээнд Шалган нэвтрүүлэх 4 цэгт ажилтан ажиллагсдын үнэмлэх, бичиг баримтыг шалган нэвтрүүлэх тоног төхөөрөмж суурилуулах, шалган нэвтрүүлэх цэгүүд дээр автомат шлагбаум суурилуулах /6ш/, 6 объектод шинээр 42ш камер тавих, хуучин 6ш камерыг шинэчлүүлэхээр саналыг “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Хууль, эрх зүйн газарт хүргүүлсэн.<br>Цагдаагийн ерөнхий газрын Олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны даргын 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр биеэр өгсөн чиг үүргийг хэрэгжүүлж, алба хаагчдын аюулгүй байдлыг хангаж, харуулын 10 цэгт ПМ гар буу 8 ширхэг, 9мм-ийн сум 36 ширхэг, АКА 2 ширхэгийг тус тус хамгаалалтанд тавьж олгон, объектын захиргаанд удаа дараа хүсэлт гаргасаны дагуу хутганаас хамгаалах хантааз 16 ширхэг, өвдөг, тохойны хамгаалалт 20 ширхэг, агсамж 40 ширхэг, энгэрийн камер 16 ширхэг, суурин болон гар металл илрүүлэгч тус бүр 2 ширхэг, хурд сааруулагч /резинэн/ 2 ширхэг, замын хаалт шон 50 ширхэг, автомат хаалт 2 ширхэг, Шалган нэвтрүүлэх I, II цэгийг албаны үйл ажиллагаанд нийцүүлэн засвар үйлчилгээ хийлгэж, зам гарцыг тээврийн хэрэгсэл шалгах, зогсох, нэвтрэх боломжтойгоор засаж, алба хаагчдын үүрэг гүйцэтгэх нөхцөл боломжийг сайжруулллаа. Цагдаагийн газраар уламжлан Цагдаагийн ерөнхий газрын Санхүү хангамжийн газраас албадан саатуулагч /зараа/ 2 ширхэгийг авч, албанд ашиглаж байна.<br>“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн ерөнхий захирлын 08 дугаар сарын 26-ны өдрийн А/473 дугаартай хяналтын нэгдсэн систем, харуул хамгаалалтыг шинэчлэн зохион байгуулах талаар гарсан тушаалтай холбогдуулан бэлэн мөнгөний кассанд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчийн аюулгүй байдалд анхаарч, ашиглагдаж байгаа хийн буу, хантааз нь шаардлага хангахгүй, алба хаагчийн эрүүл мэнд, амь насанд эрсдэлтэй байдал үүсгэж байгаа талаар танилцуулга, материал бэлтгэн ажлын хэсэгт хүргүүлсэн. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Алба хаагчийн үүрэг гүйцэтгэх нөхцөл боломжийг дээшлүүлэх, үйл ажиллагаатай нь холбоотойгоор байгууллага, иргэдээс гаргасан гомдол, хүсэлтийг үндэслэлтэй шийдвэрлэхэд үйл явдлыг бэхжүүлэн бичсэн бичлэгийг үндэслэж байх үүднээс энгэрийн камерыг шинээр олгож ашиглуулахын зэрэгцээ 2016 оны нэгдүгээр улиралд бэлэн бус торгуулийн машиныг хэвлэгчийн хамт хөрөнгийн асуудлыг шийдүүлэн авч ашиглаж байна.<br>Тус Цагдаагийн газрын “Эрдэнэт үйлдвэр” ХХК дахь Гэрээт цагдаагийн хэлтэст гал түймэр, байгалийн гамшигт үзэгдэл үүссэн үед ажиллах төлөвлөгөөнд тодотгол, шинэчлэл хийхээр ажиллаж байгаа ба бэлэн байдлын төлөвлөгөө, алба хаагчдын хаяг, утасны бүртгэл судалгаанд орсон өөрчлөлтийг тухайн бүрт нь тусган шинэчлэн гаргаж, тус Цагдаагийн газрын Шуурхай удирдлагын алба, Нийтийн хэв журам хамгаалах тасагт хүргүүлсэн.<br>“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн цех, хэсэг дээр гэмт хэрэг, зөрчил, хэргийн газрын үзлэг, хамгаалалтанд ажиллахад алба хаагчийн аюулгүй байдлыг хангах үүднээс Цагдаагийн байгууллагын бэлгэдэл, нэр бүхий хөдөлмөр хамгааллын малгай, цацруулагчтай хос ажлын хувцас, тууз зэргийг ашиглуулж, эргүүл, жижүүрийн хуваарийг төлөвлөн гаргаж танилцуулахдаа аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгч байна.<br>2016 оны 11 дүгээр сард “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, байгаль орчны хэлтсийн мэргэжилтнээр алба хаагч нарт аюулгүй ажиллагааны сургалтыг оруулсан.<br>Хэлтэс, тасгийн ажлын байранд ажиллаж байгаа офицер, ахлагч нарт ажлын цаг дуусгаад явах үедээ өрөөний цахилгаан хэрэгслийг бүрэн салгаж, хаалгаа цоожлох, лацдаж, харуулын цагдаад хүлээлгэж өгч байх талаар үүрэг өгч, лацны дэвтрийн хөтлөлт, бүртгэлд хяналт тавьж ажиллаж байна.<br>Алба хаагчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор хөдөлгөөнт эргүүл, Оросын холбооны улсын консул, Монгол банкны харуул, жижүүрийн шуурхай албаны алба хаагч нарт болон багийн цагдаа нарт хутганаас хамгаалах хантааз тавьж олгон, бүртгэлээр хүлээлцэж, үйл ажиллагаандаа ашиглаж байна.<br>Эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал хүндэрсэн болон баяр амралтын өдрүүдэд Оросын холбооны улсын консул, Монгол банкны харуул, Саатуулах байр, жижүүрийн шуурхай албанд хүч нэмэгдүүлэн ажиллаж байна.<br>Мөн эргүүлийн чиглэлд ажиллаж байгаа алба хаагч бүрийг 2-оос доошгүй бүрэлдэхүүнтэйгээр томилон ажиллуулж байгаа бөгөөд хөдөлгөөнт эргүүлийн автомашинд гадна, дотор талыг хянах камер байрлуулан ажиллаж байна. | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Саатуулах баривчлах байрны харуул хамгаалалт хэвийн, Хятад улсад үйлдвэрлэгдсэн REIWEI нэртэй RW-620C маркын 1 тирагийн хардтай аналоги камерыг суурилуулан, эрүүлжүүлэх 3 камер, баривчлах 2 өрөө, гал тогоо болон сургалтын өрөө, галт зэвсгийн өрөө, коридорын орчныг хянасан 7 ширхэг дуран ажиллаж байна. Уг камерыг шинэчлэх саналыг шаардагдах төсвийн хамт аймгийн Засаг даргын тамгын газарт хүргүүлсэн.<br>2016 оны 06 дугаар сард Оросын холбооны улсын консул, Монгол банкинд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч нарын аюулгүй байдлыг хангах зорилгоор богино долгионы гар станц Герман улсад үйлдвэрлэгдсэн 9мм-ийн Record маркын хийн буу тавьж олгон, өдөр тутмын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллаж байна. | | |
| **Хоёр. “Сайн удирдлага зохион байгуулалтыг төлөвшүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ** | | | | | |
| 2.1 Дээд байгууллагаас гаргасан тушаал, шийдвэрүүдийг хэрэгжүүлэх, үр дүнг тооцох удирдлага зохион байгуулалт | 3 | 2.1.1 Цагдаагийн газрын үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн актууд, үүрэг, даалгавар, хөтөлбөр, шийдвэрүүдийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцох. | Цагдаагийн ерөнхий газраас 2016 оны 06 дугаар сарын 10-ны өдөр “Цагдаагийн байгууллагаас 2016 онд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, биелэлт, үр дүнг тооцох, баримт бичгийн жагсаалт” батлагдан ирж, тус Цагдаагийн газрын даргын 2016 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн А/28 дугаар тушаалаар биелэлт, үр дүнг тооцож, хяналт шинжилгээ хийх жагсаалтыг батлан, хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>Тус Цагдаагийн газраас 2016 оны 03 дугаар улиралд Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоолоор баталсан 9 хөтөлбөр, Засгийн газрын тогтоолоор батлагдсан Цагдаагийн газрын үйл ажиллагаатай холбоотой 12 эрх зүйн актууд, Цагдаагийн ерөнхий газраас гаргасан тушаал, шийдвэр, хөтөлбөр, төлөвлөгөө 14, нийт 35 эрх зүйн актуудын биелэлт, үр дүнг тооцон, холбогдох газарт хүргүүлэв. | 90% | 4,5 |
| | 4 | 2.1.3."Том төрөөс ухаалаг төр лүү" зарчмыг хэрэгжүүлэх ажлын 2016 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангах. | Цагдаагийн ерөнхий газраас "Цагдаагийн байгууллагад ухаалаг төрийн зарчмыг нэвтрүүлэх чиглэлээр 2016 онд хийх ажлын төлөвлөгөө”-г 2 дугаар улиралд батлан ирүүлсэнийг хүлээн авч, тус Цагдаагийн газраас гүйцэтгэх 5 зүйл, 14 заалт бүхий ажлын төлөвлөгөөг 2016 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр гарган, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлт, үр дүнг Цагдаагийн ерөнхий газрын Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэст хүргүүлэв. | 90% | 4,5 |
| | 5 | 2.1.7. Улсын их хурлын болон аймаг, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн саналын хуудас болон санал тоолох төхөөрөмжийг сонгуулийн тойрог, хэсгийн хороонд | Цагдаагийн ерөнхий газраас алба хаагчдыг сонгуулийн үед ажиллах талаар ирүүлсэн зөвлөмж зөвлөгөө, цаг үеийн байдалтай холбогдуулан сургалтын төлөвлөгөө гарган, алба хаагчдад Сонгуулийн тухай хууль, санал авах байрны хамгаалалтанд ажиллах талаар хэсэгчилсэн байдлаар тус бүр 1 цаг, нийт 4 цагийн сургалтыг хамгаалалтын ахлах офицерууд зохион байгууллаа.<br>Монгол Улсын Их Хурлын болон орон нутгийн сонгуулийн үеэр “Цагдаагийн бие бүрэлдэхүүнийг өндөржүүлсэн бэлэн байдлын I | 100% | 5 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хүргэх, санал авах байрны хэв журмын хамгаалалтыг зохион байгуулах. | зэрэглэлд шилжүүлж ажиллуулах тухай” Цагдаагийн ерөнхий газрын даргын 2016 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн Б/330 дугаар тушаал, Орхон аймаг дахь Цагдаагийн газрын даргын 2016 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн А/32 дугаар тушаалын дагуу 2016 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 08:00 цагаас 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 09:00 цаг хүртэл албаны бэлэн байдлын I зэрэглэлд шилжүүлэн, улсын онц чухал объектын хамгаалалтыг хүч нэмэгдүүлсэн байдлаар зохион байгуулж ажилласан.<br>2016 оны 10 дугаар сарын 14-ний өдрөөс 2016 оны 10 дугаар сарын 19-ний өдрийг дуустал сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2016 оны ээлжит сонгуулийн Булган аймагт дахь сонгуулийн хэсгийн хамгаалалтад 22 алба хаагч, Орхон аймгийн Баян-Өндөр сумын сонгуулийн санал авах хэсгийн байрны хамгаалалтад 25 алба хаагчийг тус тус томилгоожуулан, үүрэг гүйцэтгүүлсэн.<br>Шинээр батлагдсан Сонгуулийн тухай хуулиар Улсын их хурал, аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгууль 2016 оны 06 дугаар сарын 29-ний өдөр, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгууль 10 дугаар сарын 18-нд зохион байгуулагдаж, сонгуулийн тойргийн болон хэсгийн хороодын судалгааг гаргаж, ажиллах хүн хүчний тооцоог Цагдаагийн ерөнхий газрын Нийтийн хэв журам хамгаалах алба, Олон нийтийн аюулгүй байдлыг хангах албанд тус тус хүргүүлэн, хамгаалалтын төлөвлөгөө, зураглал боловсруулж, Цагдаагийн газрын даргаар батлуулан, хэсгийн хороо бүрт 2 ээлжээр алба хаагчдыг томилон, алба хаагч нарт танилцуулан, бичгээр үүрэг чиглэл өгч, гэмт хэрэг, хэв журмын зөрчилгүй хамгаалалтыг зохион байгуулж ажилласан.<br>Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн үеэр Булган аймаг дахь Цагдаагийн газарт 25 алба хаагчдыг нэмэгдлээр ажиллуулсан.<br>Мөн сонгуулийн үйл ажиллагаатай холбогдолтой хэрэг маргааныг хуулийн хүрээнд шийдвэрлүүлэх зорилгоор шинээр батлагдсан “Сонгуулийн тухай хууль”, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам, “Сонгуульд нэр дэвшигчийг эрүүгийн хэрэгт шалгах журам” /код 309/, “Сонгуулийн санал хураах байр хамгаалах журам” /код 627/, нэр дэвшигч болон сонгуулийн үйл ажиллагаатай холбогдолтой, гэмт хэрэг, зөрчил, гомдол мэдээллийг хүлээн авах, илтгэх хуудас бичих, шалгах чиглэлээр сургалтын төлөвлөгөө гаргаж, сургагч багш нар бэлтгэн судлуулж, бие бүрэлдэхүүнд сургалтыг зохион байгуулсан.<br>Тус газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, хэв журмын ажил хариуцсан ахлах байцаагч нар 2016 оны Улсын их хурал, аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн үйл | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | ажиллагаатай холбоотой Дархан-Уул аймагт зохион байгуулагдсан сургалтанд, Цагдаагийн ерөнхий газрын сургалтын төв Нарстайд зохион байгуулагдсан сургалтуудад тус тус хамрагдаж, алба хаагч нарт сургалт орсон.<br>Цагдаагийн газрын албаны бэлэн байдлын төлөвлөгөөг шинэчлэн, албаны бэлэн байдлыг 3 удаа шалгаж, аймгийн хэмжээнд жагсаал цуглаан болж, эмх замбараагүй байдал үүссэн, нөхцөл байдал хүндэрсэн үед ажиллах төлөвлөгөөнүүдэд 3 удаа тодотгол хийж, бие бүрэлдэхүүнд танилцуулав. | | |
| **Гурав. "Мэргэшсэн үйл ажиллагаатай болох" гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ** | | | | | |
| 3.1. Цагдаагийн байгууллагын эрх зүйн орчинг боловсронгуй болгох үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийг нэг мөр, үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх. | 6 | 3.1.3. Бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлттэй холбогдуулан Цагдаагийн газрын алба хаагчийн ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, батлуулан, мөрдүүлэх ажлыг зохион байгуулах. | Цагдаагийн ерөнхий газрын даргын 2016 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 2а/104 дугээр албан бичгээр ирүүлсэн Төлөвлөлт, зохион байгуулалтын тасаг, Эрүүгийн цагдаагийн тасаг, Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасаг, Нийтийн хэв журам хамгаалах тасаг, Замын цагдаагийн тасгийн алба хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг хүн бүрт гардуулан өгч, даган мөрдүүлэх ажлыг зохион байгуулж ажиллаж байна. | 100% | 5 |
| | 7 | 3.1.4. Шинэчлэгдэн батлагдсан Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулийг нэр мөр хэрэглэх, хэрэгжүүлэх чиглэлээр алба хаагчдад сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах. | Цагдаагийн газрын даргын 2016 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн А/09 дүгээр тушаалаар Цагдаагийн газрын сургалтын багийг шинэчлэн байгуулж, 2016 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөг гарган батлуулаад байна. Сургалтын төлөвлөгөөний дагуу долоо хоног бүрийн Лхагва гаригт алба хаагчдад сургалтыг зохион байгуулж байна.<br>Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс, Хууль зүйн үндэсний төв, Хууль сахиулах их сургуультай хамтран зохион байгуулсан шинээр батлагдан гарсан Монгол Улсын "Эрүүгийн хууль", "Зөрчлийн тухай хууль"-ийн 2 удаагийн сургалтанд тус Цагдаагийн газрын офицер алба хаагчдыг хамруулсан.<br>Цагдаагийн газрын алба хаагчдад Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасгийн дарга, цагдаагийн хошууч Б.Батзориг 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр батлагдсан Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/, 2016 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журам, 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдөр батлагдсан "Зөрчлийн тухай хууль"-иар 2 цагийн сургалт, ахлах хэрэг бүртгэгч, цагдаагийн хошууч Б.Энх-Ертөнц 2016 оны 02 дугаар сарын 04-ний өдөр батлагдсан "Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль", 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр батлагдсан "Сонгуулийн тухай хууль"-иар 2 цагийн сургалтыг тус тус зохион байгуулав. Мөн Хууль | 100% | 5 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | зүйн яамны мэргэжилтэн н.Нарантуяа шинээр батлагдсан “Зөрчлийн тухай хууль”-иар аймгийн хуулийн байгууллагын ажилчдын дунд орсон сургалтанд тус Цагдаагийн газрын хэсгийн байцаагч нар хамрагдсан. | | |
| 3.2 Хуулиар хүлээлгэсэн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, ниитийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүи байдлыг хангах ажлын уялдааг бэхжүүлэх | 8 | 3.2.2. Урьд онуудад үйлдэгдээд гэмт этгээд нь тогтоогдоогүй үндэслэлээр түдгэлзүүлсэн хэргүүдийг газар, хэлтэс, албадын дарга нар биечлэн танилцаж шалгах, төлөвлөгөө гарган нөхөн илрүүлэх, шийдвэрлэх ажлыг зохион баигуулж, үр дүнг тооцох. | 2016 оны байдлаар Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 205 дугаар зүйлийн 205.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр түдгэлзүүлсэн хэргүүдийг илрүүлэх чиглэлээр “Илрүүлэлт-Оргодол”, “Сар шинэ”, “Халаас”, “Ломбард” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг явуулсан бөгөөд арга хэмжээний хүрээнд 48 холбогдогчтой, 52,4 сая төгрөгний хохиролтой, 84 хэрэг үйлдэл, урьд оны дугаартай 17, энэ оны дугаартай 44 хэргийг нөхөн илрүүлж, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатнаас оргон зайлсан 18 сэжигтэн, яллагдагчийг эрэн сурвалжилж олж баривчлан, холбогдох албанд нь шилжүүлэн өгч, хэргийг шийдвэрлүүлсэн.<br>Тус Цагдаагийн газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасагт байгаа эзэн холбогдогч нь тогтоогдоогүй үндэслэлээр түдгэлзүүлсэн 126 хэргийг татан авч, тасгийн дарга болон ахлах төлөөлөгч нар уншиж танилцан, баг хариуцсан төлөөлөгч нарт хуваарилан өгч, шалгах төлөвлөгөө гаргуулан, илрүүлэх чиглэлээр зааварчилга өгч, биелэлтийг тооцон ажилласан.<br>2016 оны байдлаар аймгийн хэмжээнд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 205 дугаар зүйлд заасан үндэслэлээр түдгэлзүүлсэн нийт 186 хэрэг байгаа бөгөөд ондоо болон урьд онуудад үйлдэгдээд гэмт этгээд нь тогтоогдоогүй хэргүүдийг илрүүлэх, бүртгэгдэх үедээ сэжигтнээр татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй хэргийн илрүүлэлтийн түвшинг ахиулах, түдгэлзүүлсэн хэргийн илрүүлэлтийг дээшлүүлэн, нэмж хэрэг түдгэлзүүлэх явдлыг багасгах зорилгоор Цагдаагийн газрын даргын тушаалаар “Мэргэжлийн зөвлөл” байгуулан 1 сард 2 удаа хуралдаж, бүртгэгдэх үедээ сэжигтэй этгээд нь тогтоогдоогүй хэрэг болон түдгэлзүүлсэн хэргүүдийг хурлаар авч хэлэлцүүлэн хэвшиж ажиллаж байгаа ба тайлангийн хугацаанд Цагдаагийн газрын хэмжээнд “Сар шинэ 2016”, “Нээлт-Хаалт”, “Ломбард”, ”Хулгай” зэрэг арга хэмжээг зохион байгуулж ажилласан байна.<br>Өмнөх онуудад болон энэ онд түдгэлзүүлсэн хэргүүдийг сэргээн шалгаж шийдвэрлүүлэх зорилгоор баг хариуцсан эрүүгийн төлөөлөгч, хэсгийн байцаагч, мөрдөн байцаагч нарыг баг болгон ажиллуулж, баг тус бүрээр илрүүлэлтийн түвшинг гаргаж, сарын ажил дүгнэх нэг гол шалгуур үзүүлэлт болгон авч ажилласнаар энэ оны бүртгэгдэх үедээ сэжигтнээр татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй 70 хэргээс 43 хэргийг илрүүлж, гэмт хэргийн илрүүлэлт 61.4 хувь байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 0.7 хувь өссөн үзүүлэлттэй байна.<br>2016 оны 90 хэрэг шинээр түдгэлзүүлсэнээс 21 хэргийг буюу | 80% | 4 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 23.3 хувийг сэргээн шалгаж шийдвэрлэсэн нь хүрэх түвшинг хангасан боловч Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 205 дугаар зүйлийн 205.1.2 дахь хэсэгт заасан үндэслэлээр түдгэлзүүлсэн хэрэг 2 буюу 100 хувь өссөн сөрөг үзүүлэлттэй байх тул цаашид оргосоноос түдгэлзүүлсэн хэргийн шийдвэрлэлтийг ахиулах чиглэлээр анхаарч ажиллахаар төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.<br>Өмнөх онуудад түдгэлзүүлсэн 186 хэргээс 42 хэрэг буюу 22.5 хувийг сэргээн шалгаж шийдвэрлэсэн нь урьд оны мөн үеэс 1,5 хувь өссөн үзүүлэлттэй байна.<br>Одоо аймгийн хэмжээнд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 205 дугаар зүйлд зааснаар түдгэлзүүлсэн 156 хэрэг байгаагаас Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 205 дугаар зүйлийн 205.1.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр түдгэлзүүлсэн 151, 205.1.2 дахь хэсэгт заасан үндэслэлээр түдгэлзүүлсэн 4, 205.1.7 дахь хэсэгт заасан үндэслэлээр түдгэлзүүлсэн 1 хэрэг тус тус байна. Хэргийн өнгөөр авч үзвэл хөнгөн 3 хэрэг, хүндэвтэр 126 хэрэг, хүнд 18 хэрэг, онц хүнд 10 хэрэг түдгэлзээтэй байна.<br>Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 205 дугаар зүйлийн 205.1 дэх үндэслэлээр түдгэлзүүлсэн хэргүүдийг илрүүлэх чиглэлээр “Илрүүлэлт-Оргодол”, “Шийдвэрлэлт”, “Сар шинэ” нэгдсэн арга хэмжээг явуулсан бөгөөд арга хэмжээний хүрээнд урьд оны болон энэ оны дугаартай эзэн холбогдогч нь тогтоогдоогүй 26 хэргийг нөхөн ирүүлж, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтаас оргон зайлсан 20 сэжигтэн, яллагдагчийг эрэн сурвалжилж олж баривчлан, холбогдох албанд нь шилжүүлэн өгч хэргийг шийдвэрлүүлсэн.<br>Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасагт байгаа эзэн холбогдогч нь тогтоогдоогүй үндэслэлээр түдгэлзүүлсэн хэргийг авч, тасгийн дарга болон ахлах төлөөлөгч нар уншиж танилцан, баг хариуцсан төлөөлөгч нарт хуваарилан өгч, шалгах төлөвлөгөө гаргуулан, илрүүлэх чиглэлээр зааварчилга өгч, биелэлтийг тооцон ажилласан.<br>Эрүүгийн цагдаагийн тасгийн алба хаагчид 2016 онд 196 холбогдогчтой, 738,0 сая төгрөгний хохиролтой, 327 хэрэг үйлдлийг илрүүлэн, 176 материалыг эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулахаар буюу нөхөн илрүүлсэн хэргийг шалгуулахаар Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасагт шилжүүлсэн байна. Үүнээс урьд оны болон энэ оны дугаартай 133 хэрэг үйлдлийг нөхөн илрүүлсэн.<br>Тус аймагт 2015 оны 12 дугаар сарын 06-ны шөнө иргэн Батжаргалын хашаанаас морь алдагдсан эрүүгийн 201514000623 дугаартай түдгэлзүүлсэн хэргийг О.Мөнхболд үйлдсэнийг хэсгийн байцаагч, цагдаагийн ахмад Л.Содбилэг, 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдөр аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Мэс заслын тасгаас н.Насаа гэгч нь 550,000 төгрөгний үнэтэй орос хромон гутал | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | алдсан, 2015 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Орхон аймаг Баян-Өндөр сум Зэст багт байрлах баарaнд үйлчлүүлж байсан иргэдийн булган дээл хулгайд алдагдсан хэргүүдийг Дамдинсүрэн овогтой Мөнхбат гэгч үйлдсэнийг хэсгийн байцаагч, цагдаагийн ахмад Б.Баасанжав, цагдаагийн дэслэгч М.Эрхэмзаяа, цагдаагийн дэслэгч Ш.Тэмүүжин нар нөхөн илрүүлэн шалгаж байна. | | |
| | 9 | 3.2.3. Нууц, далд аргаар бүлэг, зохион байгуулалттай үйлдэгдэж буй гэмт хэргийг илрүүлэхэд гүйцэтгэх ажлыг чиглүүлэх. | 2016 онд нийт 547 мэдээлэл, илтгэх хуудас авсанаас туслах хүчээс 149, төлөөлөгчийн мэдээлэл 398 байна. Урьд оны мөн үетэй харьцуулахад нийт авсан мэдээлэл 58,3 хувиар, туслах хүчээс авсан мэдээлэл 51,6 хувиар, төлөөлөгчийн мэдээлэл 39,1 хувиар тус тус өссөн.<br>Эзэн холбогдогч нь тогтоогдоогүй хүнд хэргийг илрүүлэх, хэн болох нь тогтоогдоогүй цогцос, сураггүй алга болсон хүнийг эрэн сурвалжилж олж тогтоох чиглэлээр шинээр 4 МСХ, нууц далд аргаар үйлдэгдсэн эдийн засгийн болон албан тушаалын гэмт хэргийг илрүүлэх чиглэлээр 3 МТХ нээн баримтжуулан шалгаж, 3МСХ хэргийг дайчлан хааж шийдвэрлэсэн. Гүйцэтгэх ажлын мөрдөн сурвалжлах хэрэгт холбогдох ажиллагааг хийж баримтжуулан ажиллаж байгаа бөгөөд урьд онд үйлдэгдээд эзэн холбогдогч нь тогтоогдоогүй хүн амины хэрэг дээр нээсэн “Баян-Тэгш” МСХ-ийг Мөрдөн байцаах газрын Онц хүнд гэмт хэрэг мөрдөх хэлтэстэй хамтран баримтжуулалтыг явуулсан.<br>Урьд онд үйлдэгдээд эзэн холбогдогч нь тогтоогдоогүй хүн амины онц хүнд хэрэг дээр нээсэн “Ёндоо”, “Хээр” МСХ-ийг идэвхижүүлэн шалгаж байна. | 80% | 4 |
| | 10 | 3.2.4. Гэмт этгээд нь тогтоогдоогүй, бусдын эд хөрөнгийг хулгайлах, түүний дотор мал хулгайлах гэмт хэргүүдийн судалгааг гарган, нөхөн илрүүлэх чиглэлээр холбогдох хэлтэс, тасгийн ажлыг уялдуулан чиглүүлж, үр дүнг тогтмол тооцож ажиллах. | Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах газрын даргын баталсан удирдамж, төлөвлөгөөний дагуу “Илрүүлэлт-Оргодол” нэгдсэн арга хэмжээг тус Цагдаагийн газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасагтай хамтран аймгийн хэмжээнд зохион явуулах ажлын хэсгийг байгуулж, салбар төлөвлөгөөг гарган ажилласан.<br>Арга хэмжээний хүрээнд Эрүүгийн цагдаагийн тасгаас эрүүгийн 201614000144, 201614000133, 201614000104, 201614000132 201614000295, 201514000474, 201614000298, 201614000329, 201614000301, 201614000303, 201614000289, 201614000284, 201614000237, 201514000495, 201214000315, 201314000008, 201514000453, 201614000107, 201614000212 дугаартай хэргүүдийг нөхөн илрүүлж, хулгайлах төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор гэмт хэрэг үйлдэгдэж байгаа газар, үйлдлийн арга, алдагдаж байгаа эд зүйл, худалдан борлуулагдаж байгаа цэг зэргээр нь судалгаа хийж, барьцаалан зээлдүүлэх газруудын барьцаанд авсан эд зүйлээр сан бүрдүүлэн, алдагдсан эд зүйлийг эрэн сурвалжлах ажлыг зохион байгуулж ажилласан. | 80% | 4 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Малын хулгайн гэмт хэрэг илрүүлэх чиглэлээр хил залгаа аймгуудын сумдын хэсгийн төлөөлөгч нартай хамтран ажиллаж, мал, мах худалдан борлуулдаг төвлөрсөн захуудад гэнэтийн шалгалт хийж, мал, мах, түүхий эдийн ченжийн судалгаанд баяжилт хийсэн.<br>Малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр “Ченж”, “Мал” хэсэгчилсэн арга хэмжээг зохион явуулж, мал, мах худалдан борлуулдаг 84 ченжийн шинэчилсэн судалгааг гарган, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Папилон санд гарын мөрийг нь оруулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр яриа таниулга хийсэн. | | |
| 11 | 3.2.5. Нутаг дэвсгэрийн төр захиргаа, хууль хяналтын байгууллагатай хамтран мал хулгайлах болон анхаарал татсан зарим төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр бүсчилсэн сургалт, зөвлөгөөниг зохион байгуулах. | Тус Цагдаагийн газрын даргын зөвлөлийн хурлаар малын хулгайн гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж байгаа ажлыг авч хэлэлцэн, цаашид хийх ажлын талаар зааварчилга, зөвлөмж өгсөн.<br>Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, харилцан мэдээлэл солилцох чиглэлээр Хангайн бүсийн аймгуудын Цагдаагийн газар, орон нутгийн удирдлагуудыг оролцуулсан зөвлөгөөнийг Орхон аймагт зохион явуулах бэлтгэл ажлыг хангаж ажилласан.<br>Мөн Булган аймаг дахь Цагдаагийн газрын Эрүүгийн цагдаагийн тасгийн алба хаагчидтай мэдээлэл шуурхай солилцох зорилгоор “БУЛ-ОР ЭЦТ” хаалттай facebook группыг нээн ажиллуулж байна. | 60% | 3 |
| 12 | 3.2.6. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтаас оргосон сэжигтэн, яллагдагчийг эрэн сурвалжилж олох ажлыг тасралтгүй, үр дүнтэй зохион байгуулах. | Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатнаас оргон зайлсан сэжигтэн, яллагдагчийг эрэн сурвалжлах, оргон зайлах явцдаа үйлдсэн хэргийг илрүүлэх ажлыг тасралтгүй зохион явуулж байгаа бөгөөд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатнаас оргон зайлсан сэжигтэн, яллагдагч 27, шүүх, прокурорын шатнаас оргон зайлсан шүүгдэгч, яллагдагч 5, бусад орон нутгаас эрэн сурвалжлагдаж байсан 10 этгээдийг олж баривчлан, холбогдох албанд нь хүлээлгэн өгсөн. Тухайлбал: Эрүүгийн 201614000474 дугаартай хэргийн сэжигтэн М.Мөнхжаргал, эрүүгийн 21125417 дугаартай хэргийн сэжигтэн Г.Пүрэвдорж, эрүүгийн 201614000342 дугаартай хэргийн сэжигтэн Ч.Нямбаяр, эрүүгийн 201614000313 дугаартай хэргийн сэжигтэн Б.Ариунболд, эрүүгийн 201514000060 дугаартай хэргийн сэжигтэн Э.Хишигзаяа, эрүүгийн 201514000135 дугаартай хэргийн оргодол Б.Мөнхцэцэг, С.Даваасүрэн, эрүүгийн 201514000474 дугаартай хэргийн сэжигтэн Т.Төмөрхуяг, эрүүгийн 201614000284 дугаартай хэргийн оргодол Л.Батбэх, эрүүгийн 201614000298 дугаартай хэргийн сэжигтэн Г.Идэрхангай, эрүүгийн 201614000301 дугаартай хэргийн сэжигтэн Б.Чулуун-Эрдэнэ нарыг тус тус эрэн сурвалжилж, олж баривчилсан.<br>Оргон зайлсан этгээд, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдийн талаар | 90% | 4,5 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | “Эрдэнэт-ASAP” facebook группэд бие бүрэлдэхүүнд шуурхай зарлан мэдээлэх ажлыг тогтмол зохион байгуулж ажилласан.<br>Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтаас оргосон сэжигтэн, яллагдагчийг эрэн сурвалжилж олох ажлыг тасралтгүй зохион байгуулан, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтаас оргосон оргодол болон яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй хэрэгт сэжиглэгдэж байгаа этгээдүүдийн судалгааг гарган, алба хаагч нарт гарын авлагаар тараан өгч ажиллаж байна. Энэ хугацаанд эрүүгийн 201614000025 дугаартай хэрэгт мөрдөн байцаалтын шатнаас оргож, эрэн сурвалжлагдаж байсан Я.Лхагвадоржийг цагдаагийн ахмад Д.Жавзмаа олж баривчлан, мөрдөн байцаагч, цагдаагийн дэслэгч П.Бат-Эрдэнэд хүлээлгэн өгсөн.<br>Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэг дэх Цагдаагийн хоёрдугаар хэлтсээс эрэн сурвалжлагдаж байсан Дашдоржийн Докторыг 2016 оны 02 дугаар сарын 15-ны өдөр цагдаагийн ахлах ахлагч Д.Нямдорж олж баривчлан, Сүхбаатар дүүрэг дэх Цагдаагийн хоёрдугаар хэлтсийн мөрдөн байцаагч, цагдаагийн дэслэгч Нямсүрэнд хүлээлгэн өгсөн.<br>Сонгинохайрхан дүүрэг дэх Цагдаагийн хоёрдугаар хэлтсээс Эрүүгийн хуулийн тусгай ангийн 148 дугаар зүйлийн 148.1 дэх хэсэгт заасан хэрэгт эрэн сурвалжлагдаж байсан Мөнхжаргалын Хишигбат, Дорноговь аймаг дахь Цагдаагийн газраас эрэн сурвалжлагдаж байсан Очирбатын Идэрцог нарыг тус газрын Саатуулах байрны эмч, цагдаагийн ахмад П.Мөнх-Очир баривчлан, харъяа газар, хэлтсүүдэд хүлээлгэн өгсөн.<br>2016 оны 07 дугаар сарын 29-ний өдөр Орхон аймаг Баян-Өндөр сум Рашаант багт Батчимэг нь үл таних хүнд зодуулж, хөнгөн гэмтэл учирсан эрүүгийн 201614000393 дугаартай хэргийн оргодол Ж.Очир гэгчийг Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх байцаагч, цагдаагийн ахмад Ц.Ганчимэг, 2016 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Орхон аймаг Баян-Өндөр сум Шанд багт иргэн О.Цэнд-Аюуш нь бусдад зодуулж, хөнгөн гэмтэл учирсан эрүүгийн 201614000316 дугаартай хэргийн оргодол Эрдэнэсайханыг хэсгийн байцаагч, цагдаагийн ахлах дэслэгч Б.Алтаншагай нар олж илрүүлэн, хэргийг прокурорт шилжүүлэн өгсөн байна. | | |
| 13 | 3 2 7. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад сэжигтэн, яллагдагчийн нуугдмал өмч, хөрөнгийг илрүүлэх, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хөрөнгийг битүүмжлэн | Хэрэг бүртгэлт, мºðäºí áàéöààëòûí ÿâöàä ñýæèãòýí, ÿëëàãäàã÷èéí íóóãäìàë ºì÷, õºðºíãèéã èëð¿¿ëýõ, áиò¿¿ì æëýí õàì ãààëàõ, ãýì ò õýðãèéí óëì ààñ ó÷èðñàí õîõèðëûã íºõºí òº뿿ëýõ àæëûí ¿ð ä¿íã äýýøë¿¿ëýí, 60 хувиас доошгүйг нөхөн төлүүлэх зорилтыг хангах чиглэлээр онцгой анхаарал хандуулан ажиллаж, энэ онд гэмт хэргийн улмаас иргэд, аж ахуйн нэгж байгууллагад учирсан 1.657.0 тэрбум төгрөгийн хохирлоос 1,021.0 тэрбум төгрөгийн хохирлыг | 100% | 5 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хамгаалах ажлын үр дүнг сайжруулах арга хэмжээ авах. | нөхөн төлүүлж, 198 сая төгрөгийн эд хөрөнгө битүүмжлэн ажилласан бөгөөд хохирол нөхөн төлүүлэлт 62 хувьтай байна. | | |
| 14 | 3.2.8. Аймгийн Прокурорын газартай хамтран түдгэлзүүлсэн хэргийн тооллого явуулж, шийдвэрлэх ажлыг зохион байгуулах. | Тус Цагдаагийн газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасагт түдгэлзээтэй байгаа хэргүүдийг 2016 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр аймгийн Прокурорын газрын хяналтын прокурор Г.Жавхлантуяа, хяналтын прокурор Ц.Идэрмөнх, туслах ажилтан И.Пүрэвзагд, ахлах хэрэг бүртгэгч, цагдаагийн хошууч Б.Энх-Ертөнц, мөрдөн байцаагч, цагдаагийн ахмад Б.Мандухай нарын бүрэлдэхүүнтэйгээр тооллогын коммис гаргаж, тооллого хийхэд урьд оны 179 хэрэг, энэ оны 8 хэрэг, нийт 187 түдгэлзүүлсэн хэрэг тоологдсон байна.<br>Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 205 дугаар зүйлийн 205.1.1 дэх хэсэгт зааснаар 183 хэрэг, 205.1.2 дахь хэсэгт зааснаар 2 хэрэг, 205.1.4 дэх хэсэгт зааснаар 1 хэрэг, 205.1.7 дахь хэсэгт зааснаар 1 хэрэг тус тус түдгэлзүүлэн тоологдсон байна.<br>Онц хүнд 2 гэмт хэргийг Мөрдөн байцаах газар болон Улсын ерөнхий Прокуророос татсан болно. Дээрхи хэргүүдээс Эрүүгийн цагдаагийн тасагтай хамтарсан шалгах төлөвлөгөө гаргаж ажилласнаар урьд оны түдгэлзээтэй 42 хэргийг сэргээн шалгаж шийдвэрлэсэн байна.<br>Одоо нийт 156 түдгэлзүүлсэн хэрэгтэй байгаагаас эзэнгүйгээс 151, сэжигтэн, яллагдагч оргон зайлсан 4 хэрэг, бусад байдлаар түдгэлзүүлсэн 1 байна. | 90% | 4,5 |
| 15 | 3.2.9. Иргэд, байгууллагаас ирүүлсэн гэмт хэрэг, зөрчлиин тухай мэдээ, мэдээлэл бүрийг бүртгэн шуурхай шалгаж, шийдвэрлэлтэд удирдлагаас тавих хяналтыг сайжруулах. | 2016 онд тус Цагдаагийн газар нийт 11633 гомдол мэдээлэл хүлээн авсан нь өмнөх оны мөн үеэс 8,7 хувиар өссөн байна.<br>Нийт бүртгэгдсэн гомдол мэдээллээс 919 буюу 7,8 хувийг гэмт хэргийн шинжтэй, үүнээс эрүүгийн хэрэг үүсгэсэн 549 буюу 59,7 хувь, нэгтгэн шалгасан 11 буюу 1,1 хувь, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан 359 буюу 39 хувийг тус тус ээлж байна.<br>Захиргааны шинжтэй гомдол мэдээлэл нийт 5830 байгаагаас 4808 буюу 82,4 хувийг бусад шийдвэрлэлтээр, 27 буюу 0,4 хувийг харьяаллын дагуу шилжүүлсэн байна.<br>Шалгагдаж буй гомдол, мэдээллийн явц, шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг долоо хоног бүр 2-3 удаа Цагдаагийн газрын удирдлага биечлэн танилцаж, хяналт тавин ажиллаж байна.<br>2016 онд иргэд, байгууллагаас тус Цагдаагийн газрын албан тушаалтанд 186 өргөдөл, санал, хүсэлт ирүүлсэнээс ажилд орох, сургуульд суралцахыг хүссэн 34, ажилд дахин орохыг хүссэн 10, ажлын байр өөрчлөх, шилжихийг хүссэн 33, захиргааны чөлөө хүссэн 81, тэтгэвэр тэтгэмж, орон сууц хүссэн 19, бусад 9 тус тус байсныг хуульд заасан хугацаанд шийдвэрлэн, хариуг өгч ажиллав. | 90% | 4,5 |
| 16 | 3.2.10. Цагдаагийн газрын | Цагдаагийн байгууллагын мэдээллийн санг баяжуулах үйл | 90% | 4,5 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | нэгдсэн санд баяжилт хийх, гэмт хэргийн болон түслах тоо бүртгэлийн заавын хэрэгжилтэд тавих хяналтыг дээшлүүлэх, энэ чиглэлээр зөвлөмж боловсруулж, биелэлт үр дүнг тооцох. | ажиллагаанд гэмт хэрэг, зөрчлийн тоо бүртгэлийн зааврыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн тус Цагдаагийн газрын даргын 2016 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн А/05 дугаар тушаалаар "Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд хандалт хийх ажлын байрыг ашиглах журам"-ыг батлан ажиллаж байна.<br>2016 онд тус Цагдаагийн газар нь гомдол мэдээллийн санд 17392 мэдээлэл, гэмт хэргийн санд 4199, захиргааны зөрчлийн санд 16404, захиргааны тоо бүртгэлийн санд 4592 мэдээлэл тус тус бүртгэгдэж, судалгаа хяналтын санд мэдээдэл бүртгэгдээгүй болно. Мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбоотой гарсан алдаа, дутагдлыг тухай бүр арилгах арга хэмжээ авч, алба хаагчдад сургалт зохион байгуулан ажиллаж байна.<br>Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн системд хүлээн авч шалгасан гомдол мэдээлэл, шийдвэрлэлт, эрүүгийн хэрэг, хэргийн оролцогчдын болон байцаан шийтгэх ажиллагааны талаарх мэдээллийг зааварчилгааны дагуу цаг хугацаанд нь оруулсан.<br>Цагдаагийн байгуулагын мэдээллийн санд хоногт иргэдээс ирүүлж байгаа дуудлага, гомдол мэдээллийг цаг тухай бүрт нь оруулж, гэмт хэрэг, зөрчлийн шийдвэрлэлтийг 7 хоног бүрийн Лхагва гарагт тулгалт хийн, хяналт тавьж байна. Алба хаагчдын сарын ажлыг дүгнэхдээ мэдээллийн нэгдсэн санд оруулсан ажлын үзүүлэлтээр дүгнэж, алба хаагч бүр мэдээллийн санд жигд ажиллах, баяжилтыг тогтмол хийх талаар эрх бүхий тасгийн дарга нараас зааварчилга бичиж, хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажиллаж байна. | | |
| 17 | 3.2.13. Эрүү, хэв журмын нөхцөл байдалтай уялдуулан зохион байгуулах нэгдсэн арга хэмжээг чанаржуулах, үр дүнг тооцож ажиллах. | 2016 онд гэмт хэрэг илрүүлэх, оргодол этгээдүүдийг эрэн сурвалжилж олж баривчлах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр 9 удаагийн нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ зохион явуулсан. Үүнд:<br>1. Цагдаагийн ерөнхий газрын даргын баталсан удирдамж, төлөвлөгөөний дагуу "Сар-Шинэ" нэгдсэн арга хэмжээг тус Цагдаагийн газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасагтай хамтран аймгийн хэмжээнд зохион явуулах ажлын хэсгийг байгуулж, салбар төлөвлөгөөг гарган ажилласан. Арга хэмжээний хүрээнд Эрүүгийн цагдаагийн тасгаас эрүүгийн 201614000019, 201514000620, 201614000005, 201514000599, 201514000607, 201614000004, 201614000018, 201614000035, 201614000026, 201514000585 201514000585 дугаартай, 201514000098 дугаартай, 201614000056 дугаартай хэргүүдийг нөхөн илрүүлж, Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасагт шилжүүлсэн.<br>Мөн Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг дэх Цагдаагийн хоёрдугаар хэлтэстэй мэдээлэл солилцож, хамтран ажилласнаар эрүүгийн 201514000585 дугаартай хэргийн сэжигтэн У.Бямбасан, | 100% | 5 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 201514000098 дугаартай хэргийн сэжигтэн Балдан овогтой Болд нарыг эрэн сурвалжилж баривчилсан.<br>2. Хулгайлах төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор гэмт хэрэг үйлдэгдэж байгаа газар, үйлдлийн арга, алдагдаж байгаа эд зүйл, худалдан борлуулагдаж байгаа цэг зэргээр нь судалгаа хийж үзсэний үндсэн дээр аймгийн хэмжээнд “Ломбард” хэсэгчилсэн арга хэмжээг зохион явуулж, нийт 156 барьцаалан зээлдүүлэх газруудад төлөвлөгөөний дагуу аймгийн Татварын хэлтэс, Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар зэрэг байгууллагуудтай хамтарсан шалгалтыг зохион явуулж, нийт барьцаалан зээлдүүлэх газруудын барьцаанд авсан эд зүйлээр сан бүрдүүлэн, алдагдсан эд зүйлийг эрэн сурвалжлах ажлыг зохион байгуулан ажилласан.<br>Мөн erdenet_lombard@yahoo.com цахим хаяг нээж, барьцаанд тавигдсан эд зүйлүүдийн талаар мэдээлэл авч хамтран ажиллаж байна. Сар шинийн баярын өмнөх өдрүүдэд Эрүүгийн цагдаагийн тасаг, Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасаг, Нийтийн хэв журам хамгаалах тасгаас хамтран хүн ихээр төвлөрсөн үйлчилгээний төв, хүнс, барааны зах болон нийтийг хамарсан үзэсгэлэн худалдаа болон бусад газруудад халаасны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, бүртгэгдсэн гэмт хэргийг илрүүлэх, мэдээ мэдээлэл цуглуулах зорилгоор “Халаас” хэсэгчилсэн арга хэмжээг 2016 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс 02 дугаар сарын 06-ны хооронд зохион явуулж ажилласан.<br>3. Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга, дэд комиссар Ж.Буянбатын 2016 оны 02 дугаар сарын 18-ны өдөр баталсан удирдамж, төлөвлөгөөний дагуу улсын хэмжээнд зохион байгуулагдаж байгаа “Тулгалт-2” нэгдсэн арга хэмжээг орон нутагтаа үр дүнтэй зохион байгуулах зорилгоор Цагдаагийн газрын даргын 2016 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А/25 дугаартай тушаал гаргаж, тус газрын Дэд бөгөөд Эрүүгийн цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч В.Алтантулхүүрээр ахлуулсан ажлын хэсэг байгуулан, арга хэмжээний салбар төлөвлөгөөг гарган ажиллаж, дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: Санд мэдээлэл оруулах үүрэг бүхий алба хаагч нартай хамтран ажиллаж, мэдээллийн тулгалтыг хийн, эрэн сурвалжлах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, зарлан мэдээлэх ажиллагааг богино хугацаанд алба хаагчдад түргэн шуурхай хүргэж ажиллахыг дарга, удирдлагуудаас үүрэг чиглэл, зааварчилга өгч ажилласан. Энэ ажлын хүрээнд эрэн сурвалжлах ажлын зарлан мэдээлэх ажлыг эрчимжүүлэх, нийт бие бүрэлдэхүүнд шуурхай хүргэх зорилгоор facebook цахим хуудсанд “Эрдэнэт-ASAP” гэсэн нэр бүхий хаалттай группыг байгуулж, Цагдаагийн газрын нийт алба хаагчдыг гишүүнээр элсүүлэн ажиллаж байна. Тулгалтаар эрэн сурвалжлалт зарлагдсан хүн, мал, цогцос, эд | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | зүйлийг нэгдсэн бүртгэлтэй тулгалт хийж, алба хаагч нарын гар дээр байгаа эрэн сурвалжлах ажлын материалтай танилцаж, олдож тогтоогдсон эсэхээр нь тулгалт хийн, “Эрэн сурвалжлах журам /код 229/”-ын 229.13.1-229.13.3-д заасныг баримтлан ASAP санд тэмдэглэл оруулж, нийт 28 мэдээллийн шийдвэрлэлтийг хийж, эрэн сурвалжлалтыг зогсоож ажилласан.<br>4. Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга, дэд комиссар Ж.Буянбатын 2016 оны 02 дугаар сарын 09-ний өдөр ирүүлсэн 3/09 тоот үүрэг, чиглэлийн хүрээнд аймгийн хэмжээнд 30 хоногоос дээш хугацаагаар оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэдийн судалгааг гарган, нэг бүрчлэн тоолох ажлыг аймгийн Тагнуулын газар, Иргэний харьяалал шилжилт, хөдөлгөөний хойд бүс дэх газартай хамтран 2016 оны 03 дугаар сарын 18-аас 03 дугаар сарын 24-ний хооронд зохион явууллаа. Орхон аймагт 2016 оны эхний 3 сарын байдлаар 24 орны 902 гадаадын иргэн бүртгэлтэй байгаагаас “Эрдэнэт үйлдвэр” ХХК-д 7 орны 661, гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалттай 38 аж ахуй нэгжид 144 гадаадын иргэн ажиллаж байна. Үүнээс Монгол улсын иргэнтэй гэр бүл болсон 17, шашны байгууллагын шугамаар ажиллаж байгаа 15, цагаач 6, суралцагч 18, Засгийн газар хоорондын шугамаар 19, Монгод улсын иргэнээс гадаад улсад төрсөн хүүхэд 14 байна. Тус аймагт бүртгэлтэй 8 орны 99 иргэн хаягандаа байхгүй нутаг буцсан гэсэн шалтгаанаар хаягандаа бүртгэгдээгүй байна. Эрүүгиéí öàãäààãèéí ãàçðûí äàðãûí 04 ðîîò àëáàí äààëãàâðûã õàíãàæ àæèëëàõ áîëîí ì ýäýýëëèéí ñ¿ëæýýãºðãºòãºõ, цаашид хяналтанд авах зорилгоор оршин суух, хөдөлмөрлөх үйл явцад тодорхой хэмжээгээр хяналт тавин, 2016 оны 02 дугаар сарын 20, 04 дүгээр сарын 17-ны өдрүүдэд төлөвлөгөөт бус шалгалт явуулсан. Мөн манай улсад зохиогдох АСЕМ-11 дээд түвшний уулзалт, Улсын их хурлын ээлжит сонгуулийн аюулгүй байдлыг хангах, болзошгүй эрсдэлийг эрт үед илрүүлж, таслан зогсоох ажлын хүрээнд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, тогтоомжийн дагуу аймгийн хэмжээнд түр болон байнга оршин сууж байгаа гадаадын иргэдийн холбогдох бичиг баримтыг нэг бүрчлэн тулгаж тоолох ажлыг зохион байгуулах, шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах чиглэлээр ажиллалаа.<br>5. Обьектын судалгаанд баяжилт хийх, гүйцэтгэх ажлын сүлжээ зохион байгуулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Такси” нэгдсэн арга хэмжээг Замын цагдаагийн тасаг, Авто тээврийн төв, Даатгуулагчдын холбоо зэрэг байгууллагуудтай хамтран зохион явуулсан. Арга хэмжээний явцад тус аймгийн хэмжээнд хот хооронд болон нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлдэг компаниудын судалгааг гаргаж, “Авто мастер” ХХК-ийн 134 жолооч нарт гэмт хэргээс урьдчилан | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | сэргийлэх чиглэлээр яриа хийж, зөвлөмж тараан өгч, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль, дүрмээр сургалт орж, таксины үйлчилгээ явуулдаг 59 хүний гарын мөрийг папилон санд оруулан, зохих зөвшөөрөлгүйгээр такси үйлчилгээ эрхэлдэг 39 хүнийг бүртгэл судалгаанд хамруулсан.<br>6. Эрүүгийн цагдаагийн газрын даргын баталсан удирдамж, төлөвлөгөөний дагуу газар тариалангийн хөнгөлөлттэй зээл авсан компаниудад үйл ажиллагааг шалгах чиглэлээр "Уринш" нэгдсэн арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион явуулж, үр дүнг илтгэх хуудсаар Эрүүгийн цагдаагийн газрын Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн даргад хүргүүлсэн. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 8 банк болон тэдгээрийн салбар болох 40 салбар нэгжид харуул хамгаалалт, аюулгүй байдлын чиглэлээр Нийтийн хэв журам хамгаалах тасагтай хамтран "Банк" хэсэгчилсэн арга хэмжээг зохион явуулж, харуул хамгаалалт, аюулгүй байдлыг шалган зааварчилж, банкны ажилтнуудад аюулгүй байдлын чиглэлээр сургалт зохион явуулсан.<br>7. Хүн худалдах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр 2016 оны 06 дугаар сарын 03-ны өдөр "Хяналт" хэсэгчилсэн арга хэмжээг зохион явуулж, Орхон аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа зочид буудал, массажны газар, баарaнд үзлэг шалгалт хийж ажилласан. Шалгалтаар Орхон аймаг Баян-Өндөр сум Оюут баг Сэлэнгэ зочид буудлын 1 давхарт иргэн Г.Мөнхзаяа нь "Релакс" нэртэй массажны газар ажиллуулан, биеэ үнэлж байсныг илрүүлэн шалгаж, Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасагт шилжүүлсэн. Мөн дуудлагаар биеэ үнэлэгч нарын утас, хаягийг тогтоон, бүртгэл судалгаанд авч ажилласан.<br>8. Гэмт хэрэг илрүүлэх, оргодол этгээдүүдийг эрэн сурвалжилж олж баривчлах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр Цагдаагийн ерөнхий газрын даргын баталсан удирдамж, төлөвлөгөөний дагуу "Оргодол-Илрүүлэлт" нэгдсэн арга хэмжээг Цагдаагийн газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасагтай хамтран аймгийн хэмжээнд зохион явуулах ажлын хэсгийг байгуулж, салбар төлөвлөгөөг гарган ажиллаж байна. Арга хэмжээний хүрээнд тус тасгаас урьд оны болон энэ оны дугаартай 16 хэрэг, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатнаас оргон зайлсан 11 сэжигтэн, яллагдагчийг эрэн сурвалжилж олж баривчлан, дүн мэдээг Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасагт нэгтгэж, холбогдох газарт хүргүүлсэн.<br>9. Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан "Зэвсэг-2016" нэгдсэн арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион явуулах ажлын хэсгийг газрын даргын тушаалаар томилон, арга хэмжээний хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг гарган батлуулж, тус газрын Нийтийн | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | хэв журам хамгаалах тасгийн алба хаагчидтай хамтран зохион явуулж байна.<br>Арга хэмжээний хүрээнд нуугдмал галт зэвсэг илрүүлэх, галт зэвсэг, байлдааны сум хууль бусаар борлуулдаг этгээдийн үйлдлийг баримтжуулах, энэ чиглэлээр нээсэн гүйцэтгэх ажлын мөрдөн сурвалжлах хэргүүдийг идэвхижүүлэн шалгах зэрэг ажлыг хийж байгаа бөгөөд хууль бусаар байлдааны сум, хэрэгсэл зарж борлуулдаг ченжүүдийг баримтжуулан шалгаж, сум хэрэгслийг хураан авч, эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулахаар 3 материалыг Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасагт шилжүүлсэн.<br>Öàãäààãèéí ãàçðààñ 2016 îíû áàéäëààð òîãîðõîé òºðëèéí ãýìò õýðãèéã áóóðóóëàõ ººðºº õýëáýë аймгийн хэмжээнд өссөлттэй байгаа гэмт хэргийг бууруулах, урьдчилан сэргийлэх, гóäàìæ òàëáàéä ¿éëäýãäñýí ãýìò õýðãèéã áóóðóóëàõ çîðèëãîîð “Тулгалт-2”, “Халаас”, “Сар шинэ”, “Такси”, “Ломбард”, “Гэр бүлийн хүчирхийллээс хохирогчийг хэрхэн хамгаалах вэ?”, “Мансуурал бидний ирээдүй биш”, “Замын хөдөлгөөний цагаан толгой”, “Цахим тоглоом”, “Илрүүлэлт”, ”Банк”, “Илрүүлэлт-Оргодол”, “Эрдмийн баяр”, ”Бүртгэл”, “Шинэ жил” зэðýã 16 íýãäñýí àðãà õýìæýý, “Цагаан сар”, “Эргүүл”, “Шалгалт”, “Тамхи”, “Дэн буудал”, “PC-тоглоом”, “Согтуурал”, “Сэтгэц”, “Зах”, “Судалгаа”, “Захирамж”, “Камер”, “Хяналт-шалгалт”, “Хонхны баяр”, “Зочид Буудал”, “Сонгууль”, “Захирамж”, “Наадам”, “Шаг”, Сонгууль” зэрэг 327-í õýñýã÷èëñýí àðãà õýìæýýã çîõèîí ÿâóóëæ, үр дүнг тооцон àæèëëàñàí .<br>Týíýì ýë, îðö òðàíøåéãààð õîíîãëîäîã 6 èðãýíèéã àéìãèéí Çàñàã äàðãûí òàìãûí ãàçðaac “Өөдрөг амьдрал” Төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулж байгаа “Түр байрлуулах байранд аваачин õàëóóí õîîë, öàéãààð ¿éë÷èëж, äóëààíû óëèðàë áîëòîë áàéëãàõ àæëûã çîõèîí áàéãóóëàí, аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний gàçàðòàé õàìòðàí îðîí ãýðã¿é èðãýäèéã á¿ðòãэлжүүлэн àæèëëàñàí .<br>“Цагаан сар”, “Мартын-8”, “Монгол цэргийн баяр”, Хүүхдийн баяр, Улсын их баяр наадам, Хангайн бүсийн хурдан морины хамгаалалт çýðýã áàÿðûí ¿åýð багийн хэсгийн байцаагч, багийн цагдаа, Олон нийтийн цагдаагийн ажилтан нарын хамт эргүүл шалгалтыг эрчимжүүлэн, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэí , ñýðэìæë¿¿ëýã õóóäàñ 680 øèðõýãèéã òàðààж, 1200 èðãýíä çºâëºãººãººñºí байна.<br>Ãýìò õýðãýýñ óðüä÷èëàí ñýðãèéëýõ òàëààð иргэд олон нийтэд хүртээмжтэй мэдээлэх зорилгоор www.police.or.gov.mn цахим хуудас болон facebook хаяг нээн ажиллуулж, иргэдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар фм-р сурталчилахаас гадна хэвлэмэл зурагт хуудас, санамж, сэрэмжлүүлгийг гудамж талбайд ил байрлуулах, иргэдэд тараах зэргээр сурталчилàí  àæèëëàæ байна. | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Àéì ãèéí Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай õàì òðàí 2016 оны 03 дугаар сарын 02-оос 2016 оны 03 дугаар сарын 07-ны өдрүүдэд Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрт цахим-тоглоом, интернэтийн үйл ажиллагаа явуулж буй нийт 25 газрыг шалган, 4 газрын үйл ажиллагааг хааж, захирал эздэд албан мэдэгдэл хүргүүлэн хариуг авч, үр дүнг тооцон ажилласан.<br>Баян-Өндөр сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн хурлаар 2016 онд хийж гүйцэтгэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын салбар төлөвлөгөөг гарган хэлэлцэж, 2016 оныг “Нохойг эзэнжүүлж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх жил” болгон зарлаж, нохойд уруулж гэмтсэн, хазуулсан Цагдаагийн газарт бүртгэгдсэн гэмт хэргийн талаар мэдээлэл оруулан хэлэлцүүлж, аймгийн 22 багийн Засаг дарга нарт Эрүүгийн хуулийн 201 дүгээр зүйл буюу “Орчиндоо аюул учруулах амьтныг зохих хамгаалалтгүй байлгах” гэмт хэргийн талаар сургалт зохион байгуулан, иргэдэд энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор сэрэмжлүүлэг тараан ажиллаж, www.police.or.gov.mn цахим хуудас болон facebook хаягаар сурталчилан ажилласны үр дүнд 2016 оны 11 дүгээр сарын байдлаар дээрхи төрлийн гэмт хэрэг 6 бүртгэгдсэн бөгөөд 25 хувиар буурсан үзүүлэлттэй байна.<br>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрөл бүрийн арга хэмжээг зохион явуулсаны үр дүнд нийт хэрэг 5.7 хувиар, гүнээс гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 87 бүртгэгдэж 7,4 хувиар, бусдын бие махбодид гэмтэл учруулах хэргүүд 6,5 хувиар, булаах хэрэг 60 хувиар, гэр бүлийн хүчирхийллийн хэрэг 15,7 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.<br>Гудамж талбайд үйлдэгдэж буй гэмт хэргийг бууруулах чиглэлээр аймгийн хэмжээнд 25 Олон нийтийн цагдаагийн ажилтныг өдөр бүр 8 цагаар эргүүлийн үүрэг гүйцэтгүүлж, 7 хоногийн 2 дахь өдөр багийн Засаг даргын ажлын албатай хамтран эргүүлийн үүрэг гүйцэтгүүлэн ажилласан.<br>Цагдаагийн газраас аймгийн Засаг даргад 2016 оны 11 дүгээр сард “Нийтийн эргүүл” ажиллуулах журам боловсруулан хүргүүлж, дээрхи санал дэмжигдэн, 2016 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн аймгийн хэмжээнд нийтийн эргүүл ажиллуулах хуваарь гарган, хэрэгжүүлж ажиллуулахаар төлөвлөөд байна. | | |
| 18 | 3.2.14.Хорих ял эдлээд суллагдсан, хорихоос өөр төрлийн ял шийтгэгдсэн, ял хойшлогдсон хүмүүст тавих захиргааны хяналтын | Î ðõîí àéì аг дахь Цàãäààãèéí ãàçàðò 2016 îíû 11 дүгээр сарын áàéäëààð 113 õ¿í çàõèðãààíû õÿíàëòàíä áàéãààãààñ хîðèõ ãàçðààñ ñóëëàãäñàí 19 õ¿í, хорихоос ººð òº ðëèéí ÿë øèéòãýãäñýí 81 õ¿í áàéна. Үүнээс 13 õ¿¿õýä ÿë õîéøëîãäîí èðñýí èéã çàõèðãààíû õÿíàëòûí õóâèéí õýðýã íýýæ, õÿíàëòàíä ààâч, òýäíèéã ñàð á¿ð Öàãäààãèéí ãàçàðò | 100% | 5 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хэрэгжилтийг мэргэжлийн удирдлагаар хангаж, үр дүнг тооцох. | öóãëóóëàí Î лон нийттэй харилцах ажил хариуцсан ахлах байцаагч, õýñãèéí áàéöààã÷ í àð õóóëü, ýðõ ç¿éí çº âлөãº º ãн, òº ðèéí áî ëî í òº ðèéí áóñ áàéãóóëëàãàòàé õàì òðàí ì ýðãýæèë î ëãî õ ñóðãàëò, òº ñº ëä õàì ðóóëàí àæèëëàæ áàéí à.<br>Mº í аймгийн Прокурорын газрын хяналтын прокурортой хамтран уулзалт зохион байгуулан, çº âлөãº º ã¿¿ëýí àæèëëàж байна. Äýýðõè çàõèðãààí û õÿí àëòòàé õ¿ì ¿¿ñýýñ î ðî í ãýðã¿é 3 èðãýí ä аймгийн Хөдөлмөр, халамжийн ¿éë÷èëãýýí èé газарт ãýð î ëãóóëàõаар материалыг хүргүүлэн, гэр олгуулах ажлыг зохион байгуулсан.<br>Захиргааны хяналтын хувийн хэргүүдийн баяжилтанд ялтны сахилга, хүмүүжлийн тухай тэмдэглэл хийлгэх, ялтныг хараа хяналтандаа байлгахаар зөвшөөрсөн иргэн, хуулийн этгээдийн төлөөлөгч нарт эрх, үүргийг бичгээр танилцуулах, ñàð á¿ð òî ãòì î ë óóëçàí õóâèéí õýðýãò òýì äýãëýãýэ õèéëãýõ çýðýã àæëóóäûã õèéëãýñýí .<br>Çàõèðãààí û õÿí àëòòàé õ¿ì ¿¿ñèéã Цàãäààãèéí ãàçàðò 10 óäàà öóãëóóëàí óóëçàæ, Ãýì ò õýðãýýñ óðüä÷èëàí ñýðãèéëýõ òóõàé õóóëü, Çàõèðãààí û õàðèóöëàãûí òóõàé õóóëü áî ëî í áócàä õóóëü òî ãòî î ì æèî ð çº âëºãº º ãсөн.<br>Öàãäààãèéí ãàçðûí х¿¿õäèéí àëáàí ààñ äýýðõè ÿë õî éø ëî ãäñî í õ¿¿õä¿¿äèéí ñóðãóóëèéí í èéãì èéí àæèëòàí , ñóðãóóëèéí çàõèðàë í àðòàé óóëçàí ÿðèëöàæ, õàì òðàí õÿí àëò òàâèí àæèëëàж, асран хамгаалагч, халамжлан хүмүүжүүлэгч томилуулж, сар бүр асран хамгаалагч нартай уулзалт зохион байгуулан ажиллалаа.<br>Захиргааны хяналтанд байгаа ялтнуудын судалгааг сар бүр гарган, Цагдаагийн ерөнхий газрын Нийтийн хэв журам хамгаалах албанд хүргүүлэн ажиллаж байна.<br>Захиргааны хяналтанд байгаа дээрхи иргэдэд Цагдаагийн газрын сэтгэл зүйчээр “Хандлага”, ”Харилцаа” сэдвээр 2 цагийн сургалтыг зохион явуулсан.<br>Захиргааны хяналтын хувийн хэргийн баяжилт, хяналт тавих ажиллагаа хууль журмын дагуу тавигдаж байгаад Улсын ерөнхий прокурорын газраас 3 удаа шалгасан бөгөөд ямар нэгэн зөрчил заагдаагүй. Шалгалтын дүнгийн талаар Цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгийн хэсгийн байцаагчид, аймгийн Прокурорын газрын хорих ял эдлүүлэх ажиллагаанд тавих хяналтын прокурор нар хурал зохион байгуулан, цаашид анхаарах асуудлын талаар ярилцсан.<br>Захиргааны хяналтанд байгаа ялтнуудыг 2016 оны 09 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн “Аминчхан яриа” Төрийн бус байгууллагатай хамтран “Өөрчлөлтийг өөрөөсөө эхлэе” сэдэвт 5 хоногийн сургалтыг зохион явуулж, давхардсан тоогоор 120 хүнийг хамруулсан.<br>Тус Цагдаагийн газар захиргааны хяналтын хувийн хэргийг аймгийн | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Прокурорын газарт тогтмол хянуулан, зөвлөгөө, зааварчилга авч ажилласан бөгөөд прокурорын шаардлага энэ онд аваагүй.<br>2016 оны 12 дугаар сарын 09-ний өдөр аймгийн Прокурорын газарт Цагдаагийн газрын 18 хэсгийн байцаагч, Олон нийттэй харилцах ажил хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн ахмад Н.Батнасан, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан шийдвэр гүйцэтгэгч дэд хурандаа Э.Амаржаргал, аймгийн Прокурорын газрын хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаанд тавих ажил хариуцсан хяналтын прокурор Э.Улаанаа нар оролцсон зөвлөгөөн зохион байгуулан, захиргааны хяналтын хувийн хэрэгт хөтлөгдвөл зохих материал, гарч буй хүндрэл бэрхшээл, цаашид хэрхэн шийдвэрлэх, хамтран ажиллах талаар зөвлөгөөн зохион байгуулсан. | | |
| | 19 | 3.2.15. Архидан согтуурахтай тэмцэх сангийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, биелэлт, үр дүнг тооцох. | 2016 онд гэр бүл àõóéí õ¿ðýýíä àðõèäàí ñîãòóóðàõ ÿâäàë èõ áàéãààòàé õîëáîãäóóëàí áàãèéí õýñãèéí áàéöààã÷, áàãèéí Çàñàã äàðãà íàðòººðººðñäèéí áàãäýýð àõóéí õ¿ðýýíä àðõèäàí ñîãòóóðäàãèðãýýäèéí ñóäàëãààг хийж, мөн гэр бүлийн хүчирхийллийн тандалтын судалгааг гарган, òýäýíä ÷èãëýñýí àðãà õýìæýýã çîõèîí ÿâóóëàõ, óðüä÷èëàí сэргийлэх талаар “Баг-Õýñãèéí áàéöààã÷-Иргэн” õàì òàðñàí áàã áàéãóóëàí àæèëëóóëæ áàéíà.<br>Мөн Орхон аймаг дахь архины аюултай хэрэглээг бууруулах зорилгоор саатуулах, баривчлах байранд хүргэгдэн ирж байгаа хүмүүст эрх зүйн болон сэтгэл заслын сургалт зохион байгуулах төсөл боловсруулан, аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд танилцуулан, зохих хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлж, 14 удаагийн 820 хүнийг хамруулсан сургалтыг зохион байгуулан ажиллаж байна.<br>Архидан согтуурах зөрчлийн талаар мэдээ, мэдээллийг нэгтгэн, орон нутгийн мэдээллийн хэрэгслээр 7 хоног бүрийн Лхагва гарагт òîãòìîë мэдээлэн, нийт 32 удаа мэдээлэл хийж, архидан согтуурах çºð÷èëèéí òàëààð ìýäýý, ìýäýýëëèéã 14 õîíîã òóòàì íýãòãýí, àéìãèéí Çàñàã äàðãà, Ãýìò õýðãýýñ óðüä÷èëàí ñýðãèéëýõ àæëûã çîõèöóóëàõ çºâëºëèéí õóðàëä òàíèëöóóëàí, íºõöºë áàéäëàà èëòãýн ¿¿ðýã ÷èãëýë àâ÷, óðüä÷èëàí ñýðãèéëýõ òàëààð õóóëü õýíàëòûí áóñàä áàéãóóëëàãà, íóòãèéí çàõèðãààíû áàéãóóëëàãóóäòàé õàì òðàí àæèëëàæ áàéíà.<br>Öàãäààãèéí ãàçðààñ согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг, çºð÷èëèéã ñóäëàí ¿çýæ, áóóðóóëàõ çîðèëãîîð àéìãèéí õýìæýýíä ¿éë àæèëëàãàà ÿâóóëæ áàéãàà àæ àõóéí íýãæ¿äèéã á¿ðýí êàìåðæóóëàõ, ãýðýëò¿¿ëýãòýé áîëãîõ àæëûã ýíý îíä ¿ðãýëæë¿¿ëýí çîõèîí áàéãóóëæ, согтууруулах ундаагаар үйлчилдэг худалдан борлуулдаг àæ àõóéí íýãæ¿äèéí ñóäàëãààнд байнгын тодотгол хийж, шинээр зөвшөөрөл авч үйл | 90% | 4,5 |

ажиллагаа эхлүүлж байгаа аж ахуйн, нэгжүүдэд àéì ãèéí Çàñàã äàðãûí òàì ãûí ãàçàðò õ¿ðã¿¿ëýí áàéãóóëëàãà, àæ àõóéí íýãæèéã ãààíà áîëîí äîòîð òàëäàà êàì åðàæóóëàëò, ãýðýëò¿¿ëýã õèéõ 2014 îíû 04 дүгээр ñàðûí 30-íû ºäðèéí À/239 дугаартай àéì ãèéí Зàñàã äàðãûí çàõèðàì æèéã õýðýãæ¿¿ëýõ àæëûã тогтмол çîõèîí байгуулж, Öàãäààãèéí ãàçðààñ камержуулалт, гэрэлтүүлэг хангалтгүй хийгдсэн áàéãóóëëàãà, àæ àõóéí íýãæèä àëáàí ìýäýãäýë õ¿ðã¿¿ëýí, àéì ãèéí õýì æýýíä øèíýýð àøèãëàëòàíä îðîõ áàðèëãà, áàéãóóëàì æèéã õ¿ëýýí àâàõäàà ãýðýëò¿¿ëýã áîëîí êàì åðàæóóëàëò õèéëãýí õ¿ëýýæ àâ÷ áàéõ çîõèöóóëàëò хийлгэн, хэвшүүлэн ажиллаж байна.

Ñóäàëãààíû áàãààñ àéì ãèéí õýì æýýíä ¿éëäýãäñýí õýðãèéí øàëòãààí íºõöºëèéã ñóäëàí ¿çýõýä èõýâ÷ëýí àðõèäàí ñîãòóóðñàí ààñ ¿¿äýëòýé áàéãàà òóë äýýðõè ñóäàëãààíû òàëààð àéì ãèéí Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зºâëºë, àéì ãèéí Çàñàã äàðãàä ñàíàë õ¿ðã¿¿ëýí, àéì ãèéí õýì æýýíä ¿éë àæèëëàãàà ÿâóóëæ áàéãàà ñîãòóóðóóëàõ óíäààãààð ¿éë÷èëãýý ÿâóóëäàã àæ àõóéí íýãæ, áàéãóóëëàãóóäûã öºº𿿻ýõ, òóñãàé çºâøººðëèéã íýì æ îëãîõã¿é áàéõ, õóóëü òîãòîîìæ çº𼖹ñºí àæ àõóéí íýãæ, áàéãóóëëàãóóäûí òóñãàé çºâøººðëèéã õ¿÷èíã¿é áîëãóóëàõ òàëààð øèëæèí àæèëëàõ талаар санал хүргүүлэн ажиллаж áàéíà.

Öàãäààãèéí ãàçðààñ àéì ãèéí õýì æýýíä ¿éëäýãäñýí ãýð á¿ëèéí õ¿÷èðõèéëëèéí ýñðýã ãýì ò õýðãèéí ñóäàëãààã ãàðãàí, õóóëü õýì àëòûí áàéãóóëëàãà, àéì ãèéí Çàñàã äàðãûí òàì ãûí ãàçàð áîëîí áàãèéí Зàñàã äàðãà, íèéãì èéí àæèëòàí íàðûí õàì òàðñàí çºâëºãººíèéã àéì ãèéí Çàñàã äàðãûí òàì ãûí ãàçàðò çîõèîí áàéãóóëàí, õýâëýë ìýäýýëëèéí õýðýãñëýýð ñóðòàë÷èëæ àæèëëàñàí.

Àéì ãèéí Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зºâëºëèéí õóðàëäààð 2015 îíä ¿éëäýãäñýí ãýì ò õýðýã, çº𿫹ëèéí øàëòãààí íºõöºëèéí ñóäàëãààã õýëýëö¿¿ëýí, 2016 îнд аймгийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, архидан согтуурахтай тэмцэх òºëºâëºãºº ãàðãàж áàòëóóëñàí. Áàÿí-ªíäºð ñóì ûí 19 áàãò õýñãèéí áàéöààã÷ á¿ð ººðñäèéí áàã äýýð согтуугаар ¿éëäýãäñýí ãýì ò õýðýã, çº𿫹ëèéí øàëòãààí íºõöºëèéí ñóäàëãààã ãàðãàæ, áàãèéí Зàñàã äàðãûí õóðàëäàà õýëýëö¿¿ëýí, áàãóóäààä çîõèîõ ãýì ò õýðãýýñ óðüä÷èëàí ñýðãèéëýõ àæèë, õýñýã÷èëñýí àðãà õýì æýýíèé òºëºâëºãºº ãàðãàí, õýðýãæ¿¿ëýí àæèëëàæ áàéíà.

2016 онд гэр бүл, орчиндоо байнга түгшүүр төрүүлдэг, архины хамааралтай болсон 289 иргэнийг áàãóóäûí õýñãèéí áàéöààã÷ íàðààð судалгааг гаргуулан нэгтгэн авч, цаашид хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.

Àрхины хамааралтай äýýðõè õ¿ì ¿¿ñийг Архидалт мансуурлын

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | эсрэг ассоциаöèéí тэргүүн Г.Уламбаяртай уулзуулан, “Архины хор холбогдол, түүнээс гарах арга зам”-сэдэвт сургалтыг зохион байгуулан, цаашид хамтран ажиллах сургалт болон архины сайн дурын эмчилгээний талаар зөв ойлголтыг өгч, сургалт сэтгэл заслын үйлчилгээг Цагдаагийн газрын сэтгэл зүйч, цагдаагийн ахмад Д.Алтаншагайгаар 5 удаа хийлгэж, үйл ажиллагааны талаар орон нутгийн хэвлэл мэдээллийн “ЛХА тэнгэр” КТВ, “Номин”, “ТВ-10” телевизүүдээр суртаёчилñàí . Мөн аймгийн Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулан, аймгийн хэмжээний гэр бүлийн хүчирхийллийн эрсдэлийн үнэлгээг тогтоон ажиллаж байна.<br>Тамхины хяналтын тухай хуулийн дагуу их, дээд сургууль болон ерөнхий боловсролын сургуулийн ойр орчмын дэлгүүрүүäýä áàéí ãà õýí àëò òàâüæ àæèëëàí , ñургуулиас 500 метрийн зайд үйл ажиллагаа явуулж, тамхи худалдàæ áàéñàí 10 èðãýí èéã èëð¿¿ëýí , Òàì õèí û хýí àëòûí òóõàé õóóëèéí äàãóó 500000 төгрөгийн торгуулийн àðãà õýì æýý àâñàí . Òàì õèí û õýí àëòûí òóõàé õóóëèéí äàãóó ãóäàì æ òàëáàéä èë çàдãàé õóäàëäààõèéæ áàéãàà 32 èðãýí èéã òóãëóóëàí ÿðèà õèéæ, 2014 îí û 09 дүгээр ñàðûí 22-íû ºäðèéí àéì ãèéí Çàñàã äàðãûí 528 дугаартай “Худалдаа үйлчилгээ явуулах байршил тогтоох тухай” захирамж ãàðãóóëàí , äýýðõè õ¿ì ¿¿ñò òàí èëöóóëж àæèëëàñàí .<br>“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн ажилчдын дунд архидан согтуурах явдал их байгаатай холбогдуулан àжилчдын äóíä архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт 1 сарын аян зохион байгуулж, аяны хүрээнд 42 албан мэдэгдэл, ñýðýì æë¿¿ëýã бичиж тараан, 36 сургалт зохион байгуулж, хэвлэл мэдээлийн хэрэгслээр 64 удаа суртаёчилан ажилласан.<br>Мансууруулагч, донтуулагч áîäèñûí òàëààð èðãýäýä урьдчилан сэргийлэх, èëð¿¿ëýõ, òàñëàí çîãñîîõ òàëààð мэргэжлийн хяналтын байгууллагуудтай хамтран мэдээлэл солилцож àæèëëàæ áàéíà. Монгол Улсын Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль тогтоомж зөрчсөн 38 аж ахуйн нэгж, иргэнийг 1692000 төгрөгөөр, Тамхины хяналтын тухай хууль зөрчсөн 10 иргэнийг 500000 төгрөгөөр, Захиргааны хариуцлагын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт зааснаар 24 аж ахуйн нэгжийг 192000 төгрөгөөр торгож, арга хэмжээ авч, хууль зөрчсөн аж ахуйн нэгж, иргэдээс хураагдсан 108 ширхэг архи,148 литр пиво, 840 хайрцаг тамхи, 898 ширхэг задгай тамхи зэргийг аймгийн захиргааны журмаар түр хураагдсан эд зүйлийг устгах улсын орлого болгох орон тооны бус комисст шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн. Архидан согтуурахтай тэмцэх хууль зөрчиж, арга хэмжээ тооцогдсон 26 àæ àõóéí íýãæèéí òóñãàé çºâøººðëèéã õ¿÷èíã¿é áîëãóóëàõ ñàíàë Çàñàã äàðãûí òàì ãûí ãàçàðò õ¿ðã¿¿ëсэн. | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Аймгийн хэмжээнд 2015 оны эхний 11 сарын байдлаар согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 216 бүртгэгдэж байсан бол 2016 оны эхний 11 сарын байдлаар согтуугаар үйлдэгдсэн 206 гэмт хэрэг үйлдэгдсэн нь 4,6 хувь, саатуулагдсан хүний тоо 5,5 хувь, захиргааны журмаар шүүхийн шийдвэрээр баривчлагдсан хүмүүсийн тоо 55,6 хувиар тус тус буурсан үзүүлэлтэй байна.<br>Мөн алба хаагчдын ажиллах нөхцөл бололцоог сайжруулах, саатуулагдсан, баривчлагдсан хүмүүсийн эрх, эрх чөлөөг хүндэтгэх тал дээр анхаарч, санаачлагатай ажиллаж, өөрсдийн нөөц бололцоог ашиглан саатуулах, баривчлах байранд 4 сая төгрөгийн урсгал засварыг хийж, хүний эрх, эрх чөлөө зөрчсөн зөрчил гаргаагүй ажилласан болно. | | |
| 20 | 3.2.16. Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр “Цохилт” нэгдсэн арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах. | Тус Цагдаагийн газраас Цагдаагийн ерөнхий газрын даргын 02 тоот албан даалгаврын хүрээнд 2016 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө гаргаж, алба хаагч нарт танилцуулан, цаашид хийх ажлыг эрчимжүүлэх үүрэг, чиглэл өгч, дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Байгаль орчны журмын эсрэг гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийг илрүүлэх чиглэлээр Нийтийн хэв журам хамгаалах тасаг, Замын цагдаагийн тасгийн алба хаагч нартай хамтран 4 газарт байнгын пост ажиллуулж, хөдөлгөөнт эргүүл шалгалтыг байнгын зохион байгуулан ажиллаж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх чиглэлээр аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Орхон аймгийн Баян-Өндөр сумын Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн, аймгийн Прокурорын газартай хамтран Байгаль орчны журмын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор албан мэдэгдлийг хүргүүлэн ажиллаж, 2 удаа Цагдаагийн газрын хэмжээнд “Хууль бусаар мод бэлтгэх, тээвэрлэх, үйл ажиллагаанд хяналт тавих” болон “Цохилт” зэрэг нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, арга хэмжээний хүрээнд Жаргалант, Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрт эргүүл шалгалтыг зохион явуулж, жолооч нарт мод, модон материалыг тээвэрлэхэд бүрдүүлэх материал, гарал үүслийн гэрчилгээ олгох, хяналт тавих журмуудын талаар яриа таниулга, зөвлөмж өгөх ажил хийгдсэн.<br>Орхон аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй мод, модон материалыг боловсруулах хөрөө рам, модон материалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг модны зах, хөрөө рам, мужааны цехүүдийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, бүртгэл судалгаатай болох, Ойн тухай хууль тогтоомж зөрчсөний улмаас үүдэн гарах хор уршгийн талаар тайлбарлан ойлгуулах ажил хийгдэж, тус аймгийн Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрт модны захын үйл ажиллагаа явуулдаг “Өндөр буурал” ХХК, “Хангай” ХХК, зүсмэл мод, модон бүтээгдэхүүний | 100% | 5 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | “Хялганат” зах зэрэг аж ахуй нэгжүүдэд Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, аймгийн Прокурорын газруудтай хамтран гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр албан мэдэгдэл хүргүүлсэн.<br>Цагдаагийн ерөнхий газраас өгсөн үүргийн хүрээнд хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд гэмт хэргийн шинжтэй 2 гомдол мэдээллийг хүлээн авч шалгаж, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах саналтай прокурорт хүргүүлж ажилласан. Мөн аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас энэ онд хууль бусаар мод бэлтгэсэн 7 зөрчилд Ойн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2.4 дэх хэсэгт зааснаар нийт 6.720.000 төгрөгийн торгууль шийтгэл ноогдуулж, 28 метр куб модыг хурааж улсын орлогод авсан байна. | | |
| 21 | 3.2.17 Зам тээврийн гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах. | Тус Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасагт иргэд, байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн зам тээврийн ослын тухай 948 дуудлага мэдээлэл ирсэнээс гэмт хэргийн шинжтэй 36 гомдол, мэдээллийг хүлээн авч, хуулийн хүрээнд шуурхай шалгаж шийдвэрлэн, тайлангийн хугацаанд хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн тухай 25 мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэн шалгасанаас тасгийн зохицуулагч нар 11 хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж, прокурорт шилжүүлэн, мөрдөн байцаалтын харъяаллаар 14 хэрэг бүртгэгдэн шалгагдсан, 782 дуудлаганд ослын дүгнэлт гаргаж, буруутай этгээдээр хохирлыг төлүүлж, даатгалын байгууллагад тодорхойлолт гаргаж ажилласан байна.<br>Нийт гэмт хэргийн 4 буюу 16.0 хувийг Эрүүгийн хуулийн 215 дугаар зүйлийн 215.3, 2 буюу 8.0 хувийг Эрүүгийн хуулийн 216 дугаар зүйлийн 216.2, 6 буюу 24.0 хувийг Эрүүгийн хуулийн 215 дугаар зүйлийн 215.2, 1 буюу 7.6 хувийг Эрүүгийн хуулийн 223 дугаар зүйлийн 223.1, 12 буюу 48.0 хувийг Эрүүгийн хуулийн 215 дугаар зүйлийн 215.1 дэх хэсэгт заасан гэмт хэргүүд эзэлж байгаа бол 5 буюу 20.0 хувийг согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг тус тус эзэлж байна. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг урьд оны мөн үеэс 14 буюу 2.8 дахин буурсан үзүүлэлттэй байна.<br>Хот хоорондын замд хяналт шалгалтыг тогтмол явуулж ажилласнаар хот хоорондын улсын чанартай замд 2 хэрэг гарч бүртгэгдсэн нь урьд оны оны мөн үеэс 6 буюу 75.0 хувиар буурсан.<br>Зам тээврийн 11 осолд холбогдох шалгалтыг явуулж, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал, материалыг прокурорт шилжүүлсэний 9 буюу 81.8 хувийг хуулийн анхны хугацаа буюу 5 хоногт шийдвэрлэсэн байна. Хэрэг бүртгэлт, захиргааны зөрчлийн шийдвэрлэлтэнд тасгийн даргаас байнга хяналт тавьж, too бүртгэлийн ажилтнуудтай тулгалт хийж ажиллаж байна.<br>2016 онд хяналт шалгалтаар 19828 зөрчил илрүүлж, зөрчил | 90% | 4,5 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | гаргасан 1115 хөдөлгөөнд оролцогчдод 785 сая 40 мянган төгрөгний торгуулийн арга хэмжээ ноогдуулж, 1495 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасаж, захиргааны арга хэмжээ ноогдуулан, зөрчлийн шийдвэрлэлтийг захиргааны зөрчлийн мэдээллийн санд тухай бүр шивж оруулан ажиллалаа.<br>Орхон аймгийн Прокурор, Цагдаагийн газрын даргын баталсан хөтөлбөрийн дагуу “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, түүнээс урьдчилан сэргийлэх зарим асуудал” сэдвээр Прокурорын газар, Цагдаагийн газар, Хууль сахиулахын их сургуулийн Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тэнхим, Шүүхийн шинжилгээний алба, жолооч бэлтгэх үйл ажиллагаа явуулж байгаа авто сургуулиуд хамтран сургалт зөвлөгөөнийг зохион байгуулсан.<br>Аймгийн хэмжээнд “Шинэ жил”, “Сар шинэ-2016”, “Согтуу”, “Хууль бус тээвэрлэлт, жолоочийн хариуцлагын даатгал, хууль журмын хэрэгжилт”, “Зогсолт зогсоол”, “Явган гарц”, “Мотоцикль”, “Аюулгүй тээвэр-техникийн хяналт”, “Осолгүй жолооч-Жаргалтай гэр бүл”, “Оюутан тээвэр-1”, “Хөдөлгөөнт эргүүл”, “Оюутан тээвэр-2”, “Хамгаалах бүс-Хамгаалалтын суудал”, “Авто тээврийн хэрэгслийн стандарт”, “Ургац-2016”, “Тусгай дуут гэрэл дохио хэрэглэх журам”, “Явган гарц”, “Жолоодох эрх” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг төлөвлөгөө, удирдамжийн дагуу зохион явуулан, үр дүнг тооцож, зөрчил гаргагчдад хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож, үйл ажиллагааны явц үр дүнгийн талаар орон нутгийн телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол мэдээлж ажиллаж байна.<br>Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож хөдөлгөөнд оролцсоноoос үүдэлтэй гарч байгаа зам тээврийн хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Согтуу” нэгдсэн арга хэмжээний хүрээнд нэгдсэн хяналт шалгалтыг Гэрээт цагдаагийн хэлтэс, Нийтийн хэв журам хамгаалах тасгийн алба хаагчид, Олон нийтийн цагдаагийн ажилтнуудтай хамтран 14 удаа зохион байгуулж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 794 зөрчлийг илрүүлж, хуулийн дагуу хариуцлага тооцож ажилласан.<br>Хууль бус хүн ба ачаа тээвэрлэлт, жолоочийн хариуцлагын даатгалгүй, хууль дүрэм зөрчиж байгаа зөрчлийг илрүүлэх, хотын дотор болон хот хоорондын замд хүн ба ачаа тээврийн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн жолооч нарт мэдээлэл, сурталчилгааны ажил зохион байгуулах чиглэлээр Орхон аймгийн Авто тээврийн төв, Албан журмын даатгалын холбооны Орхон аймгийн салбартай хамтран “Хууль бус тээвэрлэлт, жолоочийн хариуцлагын даатгал, хууль журмын хэрэгжилт” арга хэмжээг 2016 оны 03 дугаар сарын 14-ний өдрөөс 1 сарын хугацаатай зохион байгуулсан. Арга хэмжээний хүрээнд авто | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | тээврийн улсын байцаагч нар Орхон аймагт үйл ажиллагаа явуулж байгаа даатгалын байгууллагуудтай хамтарсан хяналт шалгалтыг 3 замын хяналтын постон дээр зохион байгуулж, жолоочийн хариуцлагын даатгал хийгдээгүй 26 жолоочийг даатгалд хамруулж, даатгалын гэрээнд нэр заагдаагүй 5 жолоочийг нөхөн оруулж, 3 жолоочид даатгалын хуулиар хариуцлага тооцож, хүн ба ачаа тээвэрлэх журам зөрчсөн 35 зөрчил илрүүлж, 9 жолоочид 280 мянган төгрөгний торгуулийн арга хэмжээ ноогдуулж ажиллалаа.<br>Төлөвлөгөөнд тусгагдсан сургалтын хуваарийн дагуу “Авто мастер” төв, “ББ-Од” ХХК, “Сүүтэй хадаг” ХХК, “Арвин шар зам” хоршоо зэрэг аж ахуйн нэгжүүдийн такси үйлчилгээнд явдаг 400 орчим жолоочид сургалт зохион байгуулж, эрүүгийн албатай хамтран бүртгэлжүүлж ажилласан.<br>Авто тээврийн үндэсний төвтэй хамтран хот хоорондын замд хөдөлгөөний хурд хэтрүүлсэн нийтийн тээврийн жолооч нарт хариуцлага тооцож байгаа бөгөөд хурдыг 50 хувиас дээш хэтрүүлсэн 5 жолоочийн эрхийг хасч, 27 жолоочид торгуулийн арга хэмжээ тооцсон.<br>Гэмт хэрэг, осол, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгуулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр аж ахуйн нэгж, байгууллагад 3 албан мэдэгдэл хүргүүлэн, тодорхой ажил зохиолгон хариу авч, биелэлт үр дүнг тооцсон.<br>MNS 4598:2011 стандартын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах талаар алба хаагч нарт ажлын чиглэл, үүрэг өгч ажиллаж байна.<br>“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн хүнд даацын автомашинуудын хөдөлгөөнд байнгын хяналт тавьж, стандартыг мөрдүүлж ажиллах талаар үйлдвэрийн Гэрээт цагдаагийн хэлтэстэй хамтран хяналт, шалгалт зохион байгуулж ажиллаж байгаа бөгөөд Зам тээврийн яамны холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран “Аюулгүй тээвэр-Тэнхлэгийн даац” сэдэвт арга хэмжээний хүрээнд 3-н замын хяналтын пост, Жаргалант сумын чиглэлийн хот хоорондын замд хяналт шалгалт хийж, 56 тээврийн хэрэгсэлд үзлэг шалгалт хийж, тээврийн хэрэгслийн даацыг явуулын жин ашиглан шалгаж, ачаа тээвэрлэх журам зөрчсөн, даац хэтрүүлсэн 8 зөрчил илрүүлж, 613 мянган төгрөгний торгуулийн арга хэмжээ ноогдуулж ажилласан.<br>“Замын хөдөлгөөний цагаан толгой-2016” тэмцээнийг Засаг даргын тамгын газар, Боловсролын газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс, Орхон аймгийн Улаан загалмайн хороотой хамтран зохион байгуулж, тэмцээнд мэдүүлгээ ирүүлсэн нийт 10 цэцэрлэгийн 120 хүүхэд, 20 багш хамрагдаж, тэргүүн байранд Согоот багийн 4 дүгээр цэцэрлэг шалгарч, алтан медаль, өргөмжлөл, 300 мянган төгрөг, дэд байранд Уурхайчин багийн “Одод” цэцэрлэг шалгарч, мөнгөн медаль, өргөмжлөл 200 мянган | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | төгрөг, 3 дугаар байранд Жаргалант сумын 3 дугаар цэцэрлэг шалгарч, хүрэл медаль, өргөмжлөл 100 мянган төгрөгөөр тус тус шагнаж урамшуулсан.<br>Тэмцээнд оролцсон нийт 120 хүүхэд, 20 багшид гарын бэлэг гардуулж, шилдэг “Уран зохицуулагч” шагналаар Баян-Өндөр сум, Уурхайчин багийн 7 дугаар цэцэрлэгийн 5 настай Э.Тэрбумыг шалгаруулан, Замын цагдаагийн тасгийн дарга дурсгалын зүйлээр шагнаж урамшууллаа. Тэмцээний шагнал, урамшуулал болон бусад зардалд шаардлагатай 1 сая 800 мянган төгрөгийг шийдвэрлүүлж зарцуулсан.<br>Баян-Өндөр сумын гэр хорооллын чиглэлийн авто замууд, сургууль, цэцэрлэгийн орчимд хурд саарууллагч хийх, явган хүний гарцын тэмдэг, тэмдэглэл хийх, бусад шаардлагатай тэмдэг, тэмдэглэлийн судалгааг Хот тохижуулах газрын мэргэжилтэнтэй хамтран судалгаа хийж, 146 ширхэг тэмдэг, 1512 у/м хэвтээ тэмдэглэл хийхэд шаардлагатай 73 сая 200 мянган төгрөгийг шийдвэрлүүлж, гарцын тэмдэг, тэмдэглэл хийх ажлыг “Булган АЗЗА” ТӨХК хийж гүйцэтгэж байна.<br>Цагдаагийн ерөнхий газрын даргын баталсан “Хөдөлгөөнт эргүүл” нэгдсэн арга хэмжээний удирдамж, Замын цагдаагийн албаны даргаас 12/1059 дугаартай албан бичгээр ирүүлсэн үүргийг хэрэгжүүлж, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, журмын хэрэгжилтийг хангуулж, зам тээврийн хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, хот хоорондын болон орон нутгийн замд аялал, амралтаар яваа амрагч жуулчдын аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хяналт шалгалтыг эрчимжүүлж, хариуцсан нутаг дэвсгэр дээрх орон нутгийн болон улсын чанартай авто замд 2016 оны 08 дугаар сарын 05-ны өдрөөс 2016 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийг дуустал хугацаанд 7 хоногийн 6 өдөрт нь 2 алба хаагчийг томилон ажиллуулж, 328 хүн/цагийн үүрэг гүйцэтгэж ажилласан.<br>Орхон аймгаас Жаргалант сумын Хөшөөтийн давааны чиглэлийн авто замд хийгдсэн 2*3 метрийн хэмжээтэй 8 ширхэг самбарын сурталчилгааны хулдаасан хэвлэлүүд урагдаж хуучирсан байсныг “Монгол даатгал” ХХК-ийн Орхон аймаг дахь салбараар хийлгэж, 16 ширхэг хулдаасан хэвлэлийг байрлуулсан.<br>Арга хэмжээний удирдамж, ажлын чиглэлийг Жаргалант сумын хэсгийн төлөөлөгч, цагдаа, олон нийтийн цагдаагийн ажилтнуудад хүргүүлж, цагийн хуваарийн дагуу 14 удаа хамтарсан эргүүл шалгалтыг зохион байгуулсан.<br>Хяналт, шалгалтаар бүх шалгасан тээврийн хэрэгсэл 5526, илрүүлсэн зөрчил 744, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 30, хурд | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | хэтрүүлсэн 168, хамгаалах бүс хэрэглээгүй 187, хамгаалах малгайгүй 36, бүрэн бус 130, эрхийн үнэмлэхгүй тээврийн хэрэгсэл жолоодсон 9, ачаа тээвэрлэх журам зөрчсөн 109, хүн тээвэрлэх журам зөрчсөн 21, гэрэл хэрэглэх журам зөрчсөн 11 зөрчил илрүүлж, нийт 560 хүнд 16 сая 524 мянган төгрөгний торгууль оногдуулж, 30 жолоочийн эрхийг хасч, 1436 тээврийн хэрэгслийн ачаа тээшинд үзлэг хийж ажиллалаа.<br>Цагдаагийн ерөнхий газрын Лицензийн төвийн дарга, Замын цагдаагийн албаны даргын баталсан удирдамжийн дагуу салбар төлөвлөгөө гарган, тасгийн алба хаагч нарт танилцуулж, тээврийн хэрэгсэлд “Тусгай дуут болон гэрэл дохио тавьж хэрэглэх журам”-ын хэрэгжилтийг хангуулах зорилгоор нэгдсэн арга хэмжээг 2016 оны 09 дүгээр сарын 12-ны өдрөөс 2016 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсан. Нэгдсэн арга хэмжээнд 9 аж ахуйн нэгж, байгууллагын 47 тээврийн хэрэгсэл, бичиг баримтанд шалгалт явуулахад Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Бүсийн оношилгоо эмчилгээний төв зэрэг төрийн байгууллагын автомашинуудын тээврийн хэрэгслийн гэрчилгээн дээр тусгай зөвшөөрөл дарагдаагүй, харуул хамгаалалт болон бусад чиглэлийн үйл ажиллагаа явуулж байгаа хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан зэрэг нийтлэг зөрчлүүд байна.<br>Арга хэмжээний хүрээнд тээврийн хэрэгсэл эзэмшиж байгаа жолооч нарын жолоодох эрхийн үнэмлэх, тээврийн хэрэгслийн судалгааг шинэчлэн гаргаж, фото зургаар баримтжуулан, материалжуулж ажилласан.<br>“Тусгай дуут болон гэрэл дохио тавьж хэрэглэх журам”-ын хэрэгжилттэй холбоотой Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, журмуудын холбогдох заалтуудаар сургалт зохион байгуулж, жолооч нарт хандсан зөвлөмж өгч, нэгдсэн арга хэмжээний хүрээнд хийгдсэн ажлуудыг материалжуулан ажиллалаа.<br>Орхон аймгийн Орхон цогцолбор сургууль, Баян-Өндөр цогцолбор сургуулийн 1-5 дугаар ангийн сурагчдад аймгийн Прокурорын газрын хяналтын прокурор Жавхлантуяатай хамтран сургалтын “МИНИ ДРОМ” дээр сургалт зохион байгуулж, 240 хүүхэд хамрагдсан.<br>“SCHOOL POLICE” буюу сургуулийн цагдаа эргүүл ажиллуулах чиглэлээр Боловсрол, соёл урлагийн газарт санал хүргүүлж, нийгмийн ажилтнуудтай уулзалт зохион байгуулан, санал хүсэлтийг авч тусган, журмын төслийг боловсруулж, шаардлагатай төсөв зардлын тооцоо, ерөнхий боловсролын сургууль, бага, дунд, ахлах бүлгийн хүүхдүүдийн тоо зэрэг судалгааг хийж, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | санал хүргүүлээд байна.<br>Орхон аймагт үйл ажиллагаа явуулж байгаа “ЖҮР ҮР” ХХК-тай хамтран гэр хорооллын чиглэлийн ерөнхий боловсролын 7 сургуулийг сонгон авч, 2, 3 дугаар ангийн 1500 хүүхдэд гэрэл ойлгогчтой ханцуйвч олгох ажлыг зохион байгуулж, орон нутгийн 2 телевизээр мэдээлж сурталчилсан.<br>Зам тээврийн осолд өртөж, амь нас, эрүүл мэндээрээ хохирсон иргэдийн дуу хоолойг олон нийтэд хүргэх зорилгоор “Зам тээврийн ослоор хохирогсдод хүндэтгэл үзүүлэх дэлхий нийтийн өдөр”-ийг Орхон аймагт 2016 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр тэмдэглэн өнгөрүүллээ. Арга хэмжээг зохион байгуулах төлөвлөгөө гарган батлуулж, үйл ажиллагаанд зарцуулагдах 1 сая 24 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс гаргуулж, тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд орон нутгийн “Номин”, “Мэдээллийн бирж” телевизүүдтэй хамтран зам тээврийн осол хэрэгт өртөж хохирсон иргэдийг оролцуулсан нэвтрүүлэг, улсын болон орон нутгийн хэмжээнд гарч байгаа зам тээврийн хэрэг, ослын улмаас учирч байгаа хохирлын талаар тоон үзүүлэлт, ноцтой зам тээврийн осол хэрэг, гарч байгаа шалтгаан нөхцөлийн талаар иргэдэд сэрэмжлүүлэг болгож олон удаагийн давтамжтайгаар “Тусгал”, Эрдэнэт ТВ”, “Номин”, “Мэдээллийн бирж” зэрэг телевизүүдээр мэдээлэл сэрэмжлүүлэг хийсэн.<br>Хотын дотор нийтийн тээврийн үйлчилгээнд явж байгаа “ББ-Од”, “Тод од транс” ХХК-иудын дунд болон том оврын 30 автобусны урд болон хажуу талд нь зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх санамж сэрэмжлүүлэг, ноцтой зам тээврийн осол хэргийн зурагт хулдаасан хэвлэлүүдийг байршуулан хөдөлгөөнд оролцуулсан.<br>Орхон аймагт үйл ажиллагаа явуулдаг 2 хийдийн лам нар авто ослоор хохирч, амь насаа алдсан хүмүүс, тэдгээрийн ар гэр, хохирсон иргэдэд зориулан буяны ном хурж, цугларсан хүмүүсээр зул өргөх ажиллагааг зохион явуулж, авто курсүүдийн сонсогч нарт зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх санамж сэрэмжлүүлэг, уриа лоозон бүхий зурагт самбарууд бариулан, иргэд олноор төвлөрдөг худалдаа үйлчилгээний газруудаар зогсоох, зам тээврийн осолд өртсөн автомашинууд дээр хөдөлгөөнд оролцогч нарт зориулсан уриа лоозон, сэрэмжлүүлэг байршуулсан цувааг хотын төв гудамж, гэр хорооллын төв замуудаар явуулах зэрэг ажлуудыг зохион байгууллаа.<br>Улсын хэмжээнд 2016 оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлагын ажил явагдсантай холбогдуулан цэрэг тээвэрлэлтийн үед замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор зохицуулагч 1, цагдаа зохицуулагч 8, нийт 9 алба хаагч 3 удаагийн хамгаалалт зохион байгуулж ажилласан. | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Зэвсэгт хүчний анги, байгууллагатай хамтран цэрэг тээвэрлэхээр томилогдсон авто машин бүрт техникийн урьдчилсан үзлэг, шалгалт явуулж, тухайн тээврийн хэрэгслийг жолоодохоор томилогдсон 8 жолоочийн жолоодох эрхийн үнэмлэхний ангилал тохирч байгаа эсэх мөн жолооны үнэмлэх хүчинтэй эсэх талаар лавлагаа хийж шалгахад ямар нэгэн зөрчилгүй байсан бөгөөд үүрэг гүйцэтгэхээс өмнө согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн эсэхийг шалгаж, хөтөч машинаар хамгаалж ирэх, явах маршрутын дагуу хамгаалалтыг гүйцэтгэж ажилласан.<br>Орхон аймгийн Баян-Өндөр сумын доторх авто зам, замын байгууламж, тэмдэг, тэмдэглэлд үзлэг явуулах ажлын төлөвлөгөө, хуваарийг гарган, Замын цагдаагийн тасгийн дарга, Хот тохижуулах газрын дарга нар баталж, ажлын хэсэг гарган, үзлэг шалгалтыг ажлын 5 хоногт багтаан явуулж, засварлах шаардлагатай тэмдгүүдийн зургийг авч баримтжуулан, стандартын бус, шаардлага хангахгүй, зөвшөөрөлгүй байрлуулсан тэмдгүүдийг авах, зарим нэг уулзвар, гарцан дээрхи байрлал буруу тавигдсан тэмдгүүдийг шилжүүлж байрлуулах зэрэг ажлуудыг хийж, нийт 33 тэмдгийг засуулж, хуучирч муудсан 17 тэмдгийг шинэчилж, буруу тавигдсан 9 тэмдгийн байрлалыг засуулж ажилласан.<br>Зам тээврийн хэрэг осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр орон нутгийн “Номин”, “ТВ-10”, “MBS”, “ETV”, “Эрдэнэт ТВ”, “Тусгал”, “Мэдээллийн бирж” телевизүүдээр 61 удаа, нийт 197 удаагийн давтамжтайгаар мэдээлэл, сэрэмжлүүлэг хийж ажилласан. Мөн 7 хоног бүрийн 5 дахь өдөр бүр тасгийн хэмжээнд нэгдсэн хяналт шалгалтыг хийж, “Номин” телевизтэй хамтран “Дуудлага” нэвтрүүлгийг нийт 5 удаа зохион явуулсан.<br>Замын зохион байгуулалтыг сайжруулах чиглэлээр шинээр зам барих, өргөтгөх, тэмдэг, тэмдэглэлийг нэмэгдүүлэх, хичээлийн шинэ жил эхлэхтэй холбогдуулан шаардлагатай газруудад хурд сааруулагч хийх, явган хүний гарцыг нэмэгдүүлэх, сургууль орчмын бүсийн тэмдэг тавих, хөдөлгөөний нөхцөл хүнд, огцом эргэлт, тойруу, ганга жалгатай газруудад төмөр туузан хаалт хашилт хийх чиглэлээр холбогдох газруудад саналаа хүргүүлж, хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр доорх ажлуудыг хийсэн.<br>Оюутны гудамжны 1.06 км хатуу хучилттай авто зам, Оюут багийн 2.24, 2.25 дугаар байрны авто замын өргөтгөл шинэчлэлийн ажлыг “Өлзий хутагийн наран” ХХК 507 сая төгрөгөөр, Нацагдоржийн гудамжны 0.6 км хатуу хучилттай авто зам, Холбооны уулзвараас “Баян” худалдааны төвийн уулзвар хүртэлх 0.4 км хатуу хучилттай авто замыг “Жавхлан харгуй” ХХК, “Ди Вай Кей Би” ХХК 581 сая төгрөгөөр, Шанд | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | багийн 31-32 дугаар гудамжны замын засвар, Их залуу багийн 1-5 дугаар гудамж, Яргуйт багийн 26-30 дугаар гудамжны сайжруулсан бетон зам барих ажлыг “Өлзий хутагийн наран” ХХК, “Жавхлан харгуй” ХХК-иуд 232.7 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн.<br>Баян-Өндөр сумын Согоот баг, 6.9 дүгээр байрны зүүн талын зам, Говил багийн 186 дугаар цэргийн ангийн зүүн талын зам, Баянцагаан баг, Цагдаагийн газрын зүүн урд талын зам, Их залуу багт шинээр баригдсан 15 дугаар сургуулийн урд талын зам, Их залуу баг “Номуундалай” хүнсний дэлгүүрийн урд зам, нийт 5 байршилд 4.5 метрийн өргөн, 7 сантиметрийн өндөртэй стандартын хурд сааруулагчийг хийлгэж, хэвтээ тэмдэглэлийг хийлгэж тэмдэгжүүлсэн.<br>Баян-Өндөр сумын Говил баг, Их залуу баг, Шанд багийн нутаг дэвсгэр дээрхи огцом эргэлт, ганга жалгатай хэсгүүдэд 520 метр хамгаалалтын төмөр хашлагыг “Төгс цас” ХХК 74 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн.<br>“Орхон АЗЗА” ТӨХК-д мэдэгдэл хүргүүлж, Эрдэнэт-Дархан чиглэлийн А1001 дугаартай улсын чанартай авто замд 255 м2 газарт зорчих хэсгийн эвдрэлийн нөхөөс, 324 мянган м2 талбайд зорчих хэсгийн хөвөөний засвар, 200 у/м ус зайлуулах төмөр бетон хоолой, усны шуудууны засварын ажлыг хийлгэсэн, анхааруулах болон хориглох тэмдэг 40 ширхэгийг шинээр тавиулсан, Эрдэнэт-Булган чиглэлийн А1002 дугаартай авто замд 90 мянган м2 талбайд хөвөөний засвар хийлгэж, анхааруулах болон хориглох тэмдэг 38 ширхэгийг шинээр тавиулж, нийт 160 сая төгрөгний засвар арчлалтын ажил хийгдсэн.<br>Зам тээврийн ослын улмаас нийтийн эзэмшлийн хайс, хашлага, гэрэлтүүлгийн шон, бусад байгууламжийг эвдэж гэмтээсэн 16 зөрчлийг буруутай этгээдээр хохирлыг нөхөн төлүүлж засварлуулан, “Эрдэнэт Ус дулаан түгээх сүлжээ” Орон нутгийн өмчит хувьцаат компанид хүлээлгэн өгч, ажиллаж байна.<br>Хууль зүйн сайдын 2014 оны А/158 дугаар тушаалаар баталсан “Тээврийн хэрэгслийн жолоочийн мэргэжлийн шалгалт авах, үнэмлэх олгох журам”-ыг хэрэгжүүлэх зорилгоор Орхон аймагт жолооч бэлтгэх үйл ажиллагаа явуулж байгаа нийт 19 курсийн тээврийн хэрэгсэл, анги танхим, авто дром, багшлах боловсон хүчин, сургалтын гарын авлага, сургалтын явц зэрэгт хяналт тавьж ажиллаж байгаа бөгөөд дээрхи курсүүдэд элссэн В ангиллын 1651, ВС ангиллын 42, В-ВС ангиллын 202, ВС-Д ангиллын 124, ВС-ДЕ ангиллын 150, В-ВМ ангиллын 19, А ангиллын 121, М ангиллын 88 элсэгчээс замын хөдөлгөөний дүрэм, дром, хотын жолооны шалгалтыг авч, тэнцсэн 2967 элсэгчийн материалыг хүргүүлж ажилласан.<br>Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчлөөр эрхээ | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | хасуулж, эрх сэргээх шалгалтанд орж тэнцсэн 1719, Өршөөлийн хуульд хамрагдсан 232 жолооч, үнэмлэхний хугацаа дууссан 2701 жолоочийн материалыг хүлээн авч, албан бичгээр Цагдаагийн ерөнхий газрын Лицензийн төвд хүргүүлэн ажиллалаа. | | |
| 22 | 3.2.18. Хүүхэд, гэр бүлиин хүчирхийлэлтэй тэмцэх ажлыг эрчимжүүлж, бусад хууль сахиулах болон нутгийн төр захиргааны байгууллагуудтай хамтран ажиллах ажиллагааг сайжруулж, үр дүнг тооцох. | Гэр бүлийн хүчирхийллийн аюулын эрсдэлийг тогтоох, хохирогч нарт учирч болохуйц эрсдэлийг тодорхойлох, хүчирхийллийн улмаас гарч болохуйц хор уршгаас урьдчилан сэргийлэх зорилгоор судалгаа явуулсан ба судалгааг 2 үе шаттай зохион байгуулж, 2016 оны 05 дугаар сарын 15-ны өдөр дууссан. Эрсдэлийн үнэлгээг тогтооход аймгийн хэмжээнд гэр бүлдээ хүчирхийлэл үйлддэг хүмүүсийн судалгаан дээр тулгуурлан 24 багийн 2400 айл өрх, ерөнхий боловсролын сургуулийн 1250 сурагчид энэ судалгаанд хамрагдсан.<br>Орхон аймгийн хэмжээнд нийт 28000 өрхийн 98570 хүн ам оршин суудаг ба эдгээрээс эрсдэл бүхий 2 сумын 24 багийн 2400 айл өрх буюу нийт айл өрхийн 8,6 хувиас гэр бүлийн хүчирхийллийн судалгааг авахад 957 айл өрх бюу 40,2 хув нь гэр бүлийн хүчирхийллийн ямар нэгэн эрсдэлтэй гарсан байна. Аймгийн хэмжээнд явуулсан гэр бүлийн хүчирхийллийн эрсдэлийн үнэлгээний дүнгээс криминологи судалгаа хийсэн ба эрсдэлийн түвшин өндөр 69 буюу 1,6%, эрсдэлийн түвшин дунд 188 буюу 31,4%, эрсдэлийн түвшин бага 340 буюу 57%-ийг тус тус эзэлж байна.<br>“Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хамтдаа” сэрэмжлүүлэг зурагт хуудас бэлтгэн, 500 ширхэгийг багуудад тараан байрлуулж, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор шторк нэвтрүүлэг бэлтгэн, аймгийн 6 телевиз, Цагдаагийн газрын facebook хаягаар олон нийтэд нэвтрүүлж сурталчилж байна.<br>Нийтийн хэв журам хамгаалах тасгийн хэсгийн байцаагч нарт гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор ахлах байцаагчийн 03 тоот зааварчилгаа бичиж, эрсдэлийн түвшин өндөр гарсан айл өрхийн хүчирхийлэгч нарт хэсэг хариуцсан байцаагч нар хүн тус бүр дээр хяналтын хувийн хэрэг нээж, хяналтандаа авч хамтран ажиллаж байна.<br>Төвийн бүсийн Цагдаагийн байгууллагын “Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд инноваци нэвтрүүлэх нь” сэдэвт эрдэм шинжилгээний хуралд Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх байцаагч, цагдаагийн ахмад Ц.Ганчимэг “Гэр бүлийн хүчирхийлэл ба сэтгэцийн эмгэг” сэдэвт илтгэл бичиж оролцсон.<br>“Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хамгаалах байр”-ны “Ариун хэлхээ” төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж байгаа ба Баасан гариг бүр байцаагч нар “Ариун хэлхээ” төрийн бус байгууллагын сэтгэл | 90% | 4,5 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | зүйч Э.Бямбасүрэн нар хамтран Саатуулах байрны баривчлагдсан хүмүүст сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, хандлагыг өөрчлөх, ярилцлага хийх аргаар сургалтуудыг орж мөн тус байгууллагаас гаргасан хохирогчдод зориулсан зөвлөмж 300 ширхэг гарын авлага материалыг өргөдөл, гомдол шалгахдаа хохирогч нарт тараан өгч ажиллаж байна.<br>Мөн хохирогч хамгаалах байранд хүргэгдэн ирсэн хохирогч нарт хамтран гэр бүлийн хүчирхийллийн эрсдэлийн үнэлгээ тогтоож, хамтарсан багт холбон зуучлах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.<br>"Хохирогчийг хамгаалах төв" нэртэйгээр "Оюу" сэтгэц, наркологийн эмнэлгийн байрыг түшиглэн 24 цагийн үйл ажиллагаатайгаар ашиглалтанд орж, уг байр нь 70356001 дугаарын утас ажиллуулан, энэ байрны үйл ажиллагааг "Ариун хэлхээ" төрийн бус байгууллага явуулж, уг газарт хандаж зөвлөгөө авсан 112 хүн байгаагаас хохирогчийг түр хамгаалах байранд 21 эмэгтэй 47 хүүхдийн хамт нийт 284 ор хоног хамгаалах байранд очиж байрласан байх бөгөөд тус байгууллагатай Цагдаагийн байгууллага хамтран ажиллаж, 2 эмэгтэй, 3 хүүхдийн хандалтын асуудлыг шалган шийдвэрлэж, хамтарсан багаар нийгэм, халамжийн үйлчилгээ үзүүлж ажилласан байна.<br>Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллагуудаар уриалга, удирдамжтай "Аз жаргалтай гэр бүл" аяны дэвтэр аялуулан, байгуулага бүр дээр 7 хоногийн хугацаанд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх шинэлэг ажил, шторк, гарын авлага бэлтгэх, шинэчлэн батлагдсан "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль"-иар сургалт хамт олондоо сурталчилах, гэр бүлийн хүрээнд тэмцээн уралдаан зохион байгуулах зэрэг ажлуудыг зохион байгуулж, энэ талаар Цагдаагийн газрын facebook хаягаар сурталчилж ажиллаж байна.<br>"Монгол дахь жендерт суурилсан хүчирхийллийг зогсоох, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хамгаалах байрыг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх нь" хөтөлбөрийн хүрээнд Америкийн нэгдсэн улсын Аляск мужаас ирсэн экспертүүд мөн аймгийн энэ чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зөвлөгөөнд байцаагч нар санал, бодлоо солилцож оролцсон.<br>Гэр бүлийн хүчирхийллийн эрсдэлтэй гарсан 597 айл өрхийн гэр бүлийн хүчирхийлэгч 403 хүнийг Цагдаагийн байгууллагын Судалгаа хяналтын санд Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх байцаагч нар шивж оруулсан ба шинээр батлагдсан "Хүүхдийн эрхийн тухай хууль, шинэчилсэн найруулга хийгдсэн "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль"-ийн талаар Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газрын дарга Ph доктор Х.Баавгай 2016 оны 06 дугаар сарын | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 07-нд Засаг даргын Тамгын газрын хурлын зааланд зохион байгуулсан сургалтанд Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх байцаагч нар хамрагдсан.<br>Иргэд олон нийтийн гэр бүлийн хүчирхийллийн талаархи ойлголт, мэдлэг, хандлага, ухамсрыг дээшлүүлэх зорилгоор ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийхныг сургууль бүрээр нэг өдөр Цагдаагийн байгууллагыг сурталчилах өдөр болгон, энэ үеэр сурагчдад Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх байцаагч нар сургалт орж, Цагдаагийн албанд ашиглагдаж байгаа галт зэвсэг, тусгай хэрэгслээр үзүүлэн гарган танилцуулж, Хууль сахиулахын их сургуульд ямар журмаар бүртгүүлж, шалгалт өгч ордог талаар яриа хийсэн.<br>Мөн тасаг, албад бүр графикын дагуу сар бүр “Нээлттэй хаалганы өдөр”-ийг тус тус зохион явуулдаг ба гэр бүлийн хүчирхийллийн талаарх “Хүчирхийллийн эсрэг хамтдаа” сэдэвт наадаг зурагт хуудас 500 ширхэгийг хэвлүүлэн, томоохон худалдааны төв, хүнс, бараан зах, олон нийтийн газар наан байршуулж, иргэдэд тараан, гэр бүлийн хүчирхийллийн талаар ойлголт, мэдлэг өгч, тэднээс санал, хүсэлтийг нь хүлээн авч ажилласан. | | |
| 3.3.Үйл ажиллагааны төлөвлөлт,тайлан, ил тод нээлттэй байдлыг хангах, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх талаар | 23 | 3.3.1 Цагдаагийн газрын даргаас Төсвийн шууд захирагч Цагдаагийн ерөнхий газрын даргатай 2015 онд байгуулсан үр дүнгийн гэрээг дүгнэж, 2016 оны үр дүнгийн гэрээ байгуулах. | Төсвийн шууд захирагч Цагдаагийн ерөнхий газрын даргатай, тус Цагдаагийн газрын дарга, ерөнхий менежерээс 2015 онд байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт 94.5 хувийн гүйцэтгэл, 4.72 оноотой дүгнэгдсэн.<br>2016 оны үр дүнгийн гэрээний төслийг хугацаанд нь Цагдаагийн ерөнхий газарт хүргүүлэн, үр дүнгийн гэрээг байгуулав. | 100% | 5 |
| | 24 | 3.3.2 Цагдаагийн газрын дарга нэгжийн менежертэй, нэгжийн менежерээс алба хаагч нартай 2016 оны үр дүнгийн гэрээг мөн оны 01 дүгээр сард багтаан байгуулж, үр дүнг тооцох. | 2016 онд Цагдаагийн газрын даргаас 351 алба хаагчидтай /Эрүүгийн тасгийн 15 алба хаагчидтай байгуулаагүй болно/ үр дүнгийн гэрээ байгуулан ажиллаж байна.<br>Аёáà õàà㷸äû í  àæëû ã ñàð á¿ðèéí  25-í ы ºäðºº ð òàñàëáàð áî ëãî í  Монгол Улсын “Òº ðèéí  àëáàí û  тухай хууль”-ийн19 дүгээр зүйл, Öàãààëàãèéí  åðº í õèé  ãàçðû í  2015 î í û  04 дүгээр сарын 22-ны өдрийн А/25 дугаар тушаалаар батлагдсан “Алба хаагчийн ажлыг үнэлэх журам” /код 111/-ыг дагуу дүгнэж байна.<br>2016 онд 189 алба хаагчийн цалинг 5-20 хувь нэмж, 91 алба хаагчийн цалинг 5-20 хувь хасч, ажлын үр дүнг тооцов. | 100% | 5 |
| | 25 | 3.3.3 Авлигаас урьдчилан сэргийлэх тус Цагдаагийн газрын салбар зөвлөлийн 2016 онд хийх ажлын | Орхон аймаг дахь Цагдаагийн газрын Авлигаас урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн 2016 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг гарган, Цагдаагийн газрын даргаар батлуулж, үр дүнг хагас, бүтэн жилээр тооцож ажилласан. | 90% | 4,5 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангах, биелэлт, үр дүнг тооцох. | Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн сургалтын хөтөлбөрийн дагуу Орхон аймаг дахь "Эрдэнэт медипас" эмнэлгийн ажилчид болон гаалийн нийт ажилчдад 4 цагийн сургалт орсон. Авлигатай тэмцэх газраас ирсэн сургалтанд тус газрын нийт алба хаагчдыг хамруулж, төрийн алба хаагч нарт зохион байгуулсан сургалтанд офицер бүрэлдэхүүнийг хамруулсан. Мөн офицер бүрэлдэхүүнээс Авлигатай тэмцэх хуулийг судлуулж, баталгаа гаргуулан авч ажиллалаа.<br>Цагдаагийн ерөнхий газрын Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2016 оны төлөвлөгөөг удирдлага болгон Орхон аймаг дахь Цагдаагийн газрын Авлигаас урьдчилан сэргийлэх салбар зөвлөлөөс 2016 онд хийх ажлын төлөвлөгөөг гарган, газрын даргаар батлуулж, үр дүнг тооцон, дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Авлигаас урьдчилан сэргийлэх орон тооны бус салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, даргаар нь Цагдаагийн газрын Дэд бөгөөд Эрүүгийн цагдаагийн тасгийн дарга ажиллаж байна.<br>Авлигаас урьдчилан сэргийлэх ажилд зориулсан санхүүжилтийг шийдвэрлэх зорилгоор аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга М.Мөнхбаярт албан бичиг хүргүүлсэн ба одоогоор шийдвэрлэгдээгүй байна.<br>Авлигын эсрэг Монгол Улсын хууль тогтоомж, Авлигаас урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа, Хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргагчид өгөх зөвлөмж, Авлигатай тэмцэхэд та хувь нэмрээ оруулж чадна, Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиас "Авлигыг үл тэвчье" зэрэг гарчигуудтай авлигаас урьдчилан сэргийлэх ажлын мэдээ, мэдээлэл бүхий самбарыг Цагдаагийн газрын үүдэнд байрлуулан, 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу мэдээллүүдийг шинэчлэн байршуулан ажиллаж байна.<br>Тус цагдаагийн газрын офицер бүрэлдэхүүний хөрөнгө орлогын мэдүүлгийг цаг хугацаанд нь гарган хүргүүлж ажиллалаа.<br>Цагдаагийн газрын үйл ажиллагаа, аймгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын мэдээг иргэд олон нийтэд хүртээмжтэй мэдээлэх, Цагдаагийн байгууллагын төсөв санхүүгийн ил тод байдлыг хангах зорилгоор шилэн дансны мэдээллийг www.police.or.gov.mn цахим хуудас болон www.facebook.com хаягт байршуулан ажиллаж байна.<br>Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг тус Цагдаагийн газрын цахим хуудас www.police.or.gov.mn болон байгууллагын мэдээллийн самбарт сар бүрийн 5-нд шинэчлэн тавьж хэвшил болсон. Одоогоор авлигын чиглэлээр ямар нэгэн үйлдэл бүртгэгдээгүй байна. | | |
| 26 | 3.3.4. "Ил тод баидлыг илтгэх шалгуур үзүүлэлт | Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа болон алба хаагчтай холбоотой санал, хүсэлт, гэмт хэрэг, зөрчлийн мэдээ, мэдээлэл хүлээн | 100% | 5 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | батлах тухай" Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцох. | авах, иргэд олон нийтэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, цагдаагийн газрын ил тод байдлыг хангах зорилгоор байгууллагын цахим хаяг www.orkhon.police.gov.mn, www.facebook.com/Орхон_Аймгийн_Цагдаагийн_Газар,www.twitter.com/Orkhon_Police цахим хуудсуудыг нэвтрүүлэн ажиллаж байна.<br>Тус Цагдаагийн газрын даргын Б/91 дүгээр “Цахим хуудас хариуцсан ажилтан томилох тухай” тушаалаар уг ажил үүргийг гүйцэтгүүлэхээр Холбоо мэдээллийн инженер, цагдаагийн ахлах дэслэгч Б.Мөнгөнтуулыг томилон, маягт: ЦБҮАЖ № 135.42 “а”, “б”, “в”, 135.61, 135.3 “а”, “б”-д заасан Цагдаагийн газрын цахим хуудсанд оруулах үйл ажиллагааны ил тод байдлыг хангах мэдээллийг журамд заасан хугацаанд бэлтгэн, цахим хуудсыг хариуцсан ажилтанд хүргүүлэн ажиллах 9 алба хаагчийг тушаалын хавсралтаар батлан ажиллаж байна. Тухайлбал: Удирдлага зохион байгуулалт, зөвшөөрөл, бүртгэл, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд тавих иргэний хяналт, олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа, хүний нөөцийн ажиллагаа, төсөв, санхүү, тендер, сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа, олон нийтийн цахим хуудсанд байгууллагын үйл ажиллагааг сурталчилах, авилгын эсрэг үйл ажиллагаа гэсэн 8 мэдээллийн бүтэцээр тус тусад нь хариуцсан алба хаагч ажиллаж байна.<br>Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хуулиар хориглоогүй аливаа мэдээллийг иргэдэд үнэ төлбөргүй, хүндрэл чирэгдэлгүй өгөх ажиллагаа хэвийн хэмжээнд явагдаж байна.<br>Тус газрын иргэдийг хүлээн авах танхимд Цагдаагийн газрын үйл ажиллагааны талаарх бүх мэдээллийг иргэд өөрсдөө сонгон авах зорилгоор SHARP брендийн 42 инчийн TOUCH LCD телевиз, 2 ширхэг Android box, хэрэглээний програм хангамжийн хамт нийт 5.000.000 /таван сая/ төгрөгийн өртөгөөр суурилуулсан.<br>Жижүүрийн албаны мэдээлэл хүлээн авагч цагдаа нь иргэдээс гаргасан санал, хүсэлтийг хүлээн авч тэмдэглэн, холбогдох ажилтнуудад танилцуулж, иргэдийг хүлээх авах танхимд санал, хүсэлтийн хайрцгийг ил тод байрлуулсан.<br>Байгууллагынхаа тухайн оны төсөв, төсвийн гүйцэтгэлийн талаар аймгийн нэгдсэн цахим хуудас болох www.erdenet.mn хаяганд байршуулсан. | | |
| 27 | 3.3.6. Цагдаагийн газраас хариуцсан нутаг дэвсгэрийн Иргэний зөвлөл болон иргэд олон нийтэд ажлаа тайлагнаж, гарсан санал, зөвлөмжийн дагуу | Цагдаагийн албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт заасначаар аéì ãèéí Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдэд 2016 оны 08 дугаар сарын 01-ний өдөр Цагдаагийн газрын дарга, зөвлөлийн гишүүд 2016 оны эхний хагас жилийн үйл ажиллагааныхаа тайланг тавьсан. Тайланг хэлэлцээд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдээс Цагдаагийн газрын үйл ажиллагааг “Хангалттай | 90% | 4,5 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | тодорхой ажил зохион байгуулж, үр дүнг тооцох. | сайн” ажиллаж байна гэсэн үнэлгээг өгсөн бөгөөд Цагдаагийн газрын үйл ажиллагааг болон хэрэгцээтэй тоног төхөөрөмж бусад материалаар бүрэн дэмжихээ илэрхийлэн, цаашид анхаарах асуудлын талаар үүрэг чиглэл өгсөн.<br>Àéì ãèéí Гýì ò õýðãýýñ óðüä÷èëàí ñýðãèéëýõ àæëûã çîõèöóóëàõ çºâëºëèéí õóðàëä тогтмол оролцон, гэмт хэрэг, зөрчлийн талаар íºõöºë áàéäëàà 11 удаа òàí èëöóóëàí àæèëëàсан.<br>2016 îíû 02 дугаар ñàðä õóðàëäсан òºñâèéí òîãòîîëîîð 2016 онд ажиллах 25 Олон нийтийн цагдаагийн ажилтны цалин 164 сая 464 мянган төгрөгийг øèéä¿¿ëýн, үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.<br>Аймгийн Çàñàã äàðãûí øóóðõàé çºâëºãºîí äýýð àéìãèéí ýð¿¿ãèéí áîëîí õýâ æóðìûí íºõöºë áàéäëûí òàëààð ìýäýýëэл хийж, Çасаг даргын тамгын газрын Õууль, эрх зүйн хэлтэст 7 хоног бүр гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээг өгч ажиллаæáàéíà.<br>Аймгийн иргэдэд 2016 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Цагдаагийн байгууллагаас 2016 оны эхний хагас жилд хийж гүйцэтгэсэн ажлаа тайлагнан, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн байна. Тайлангийн үер 115 санал хүсэлт, талархал иргэдээс гаргасаныг газар дээр нь болон холбогдох газарт нь уламжлан хариуг өгч, шийдвэрлэн ажилласан.<br>Иргэдээс гаргасан саналын дийлэнх хэсэгт гэрэлтүүлэг болон камержуулах талаар санал гарсаныг Цагдаагийн газраас хүлээн авч, аймгийн хэмжээнд гэрэлтүүлэг, камержуулалт шаардлагатай 193 цэгийн судалгааг гарган, аймгийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хуралд саналаа хүргүүлэн ажиллаж, 2016 онд гэрэлтүүлгийн ажил бүрэн шийдэгдэхээр болсон.<br>Цагдаагийн албаны тухай хуулинд зааснаар Иргэний зөвлөлд 2016 оны эхний 10 сарын ажлаа тайлагнасан бөгөөд Иргэний зөвлөлийн 2 гишүүн шинээр сонгогдсонтой холбогдуулан Цагдаагийн газрын алба хаагч нартай Иргэний зөвлөлийн гишүүд уулзалт зохион байгуулан, яриа хийж, санал хүсэлтийг сонссон.<br>Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа болон алба хаагчтай холбоотой санал, хүсэлт, гэмт хэрэг, зөрчлийн мэдээ, мэдээлэл хүлээн авах, иргэд олон нийтэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, цагдаагийн газрын ил тод байдлыг хангах зорилгоор байгууллагын цахим хаяг www.orkhon.police.gov.mn, www.facebook.com/ Орхон_Аймгийн_Цагдаагийн_Газар, www.twitter.com /Orkhon_Police цахим хуудсуудыг нэвтрүүлэн ажиллаж байна.<br>Тус Цагдаагийн газрын 40 жилийн ойн баярын ажлын хүрээнд аймгийн иргэдэд Уурхайчин соёлын ордонд нээлттэй хурал, зөвлөгөөн зохион байгуулан ажиллаж, үйл ажиллагааныхаа талаар мэдээлэл хийн, | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | иргэдийн санал, хүсэлтийг сонсож ажилласан. Цагдаагийн газарт ажиллаж байгаа Олон нийтийн цагдаагийн ажилтны талаарх танилцуулга, мэдээллийг Иргэний зөвлөлийн удирдлагуудад 2016 оны 08 дугаар сард танилцуулан ажиллаж, цаашид хэрхэн ажиллах, цалин урамшууллыг шийдвэрлэх талаар санал хүсэлт гарган, аймгийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хуралд хүргүүлэхээр шийдвэрлүүлсэн.<br>Мөн 2016 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Баян-Өндөр сумын 22 багийн Иргэдийн нийтийн хурлын үед баг хариуцсан хэсгийн байцаагч нар өөрсдийн баг дээр Цагдаагийн газраас хийж гүйцэтгэсэн ажил болон үйл ажиллагааныхаа тайланг иргэдэд тайлагнасан. Тайлангийн үеэр иргэдээс гарсан саналын дагуу гэр хорооллын багууд, Дэнж, Говил, Эрдэнэ багуудад нэмэгдэл эргүүл ажиллуулах, Яргуйт багт шинээр хэсгийн байцаагч, багийн цагдаа нэмэх санал гарсаныг шийдвэрлүүлэхээр уламжлаад байна. | | |
| 28 | 3.3.7. Хүний эрхийн үндэсний комисстой байгуулсан “Санамж бичиг”, хамтран ажиллах төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах. | Цагдаагийн газрын хэмжээнд зохиогдох албаны сургалтыг Цагдаагийн Ерөнхий Газрын хүний нөөц, сургалтын хэлтсээс ирүүлсэн хөтөлбөрийн дагуу зохион байгуулж цагдаагийн газрын даргын тушаалаар сургалтын төлөвлөгөөг батлуулан тасгууд өөрсдийн чиглэлээр, бие бүрэлдэхүүн нэгдсэн байдлаар явуулав. Алба хаагч нарын хууль эрх зүй, албаны мэдлэг чадвар зэвсэг техник, бие бялдар, гадаад хэл, компьютер болон сахилга ёс зүйг дээшлүүлэх зорилгоор сургалт, соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлж байна. Алба хаагчдад явуулах сургалтын төлөвлгөөг боловсруулж 7 хоног бүрийн Даваа, Лхагва гарагийн 09 цагаас 11 цагийн хооронд сургалтыг зохион байгууллаа.<br>Хүний эрхийн үндэсний комиссын Орхон аймаг дахь салбарын ахлах мэргэжилтэн Ё.Эрдэнэболдтой хамтарч хүний эрхийн боловсрол олгох сургалтыг хамтран зохион байгуулах ажлын төлөвлөгөөг гарган, Цагдаагийн газрын хурлын заалыг хичээл сургалтын танхимаар ашиглаж хэсгийн байцаагч нараар гэмт хэрэг үйлдэж болзошгүй болон гэмт хэрэг үйлдэн захиргааны хяналтанд байгаа хүмүүсийн судалгааг гарган, холбогдох хүмүүст сургалтыг зохион байгуулж ажилласан. Нийт давхардсан тоогоор 6 удаагийн 12 цагийн сургалтанд 198 хүн хамрагдсан ба сургалтын танхимыг Цагдаагийн газрын хурлын заал болон ерөнхий боловсролын сургуулийн урлаг соёлын зааланд явуулж ажилласан байна. | 90% | 4,5 |
| 29 | 3.3.8. Прокурорын шаардлага бүриин мөрөөр тодорхой ажил зохион байгуулж, шалтгааныг тогтоох, биелэлтэд нь | Тус Цагдаагийн газарт аймгийн Прокурорын газраас 2016 онд прокурорын 4 шаарлага ирүүлсэнээс Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасагт 3, Нийтийн хэв журам хамгаалах тасагт 1 шаардлага хамааралтай байна.<br>Аймгийн Прокурорын газрын 2016 оны 08 дугаар сарын 03-ны | 90% | 4,5 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хяналт тавих, хариуцлага тооцох, хариу хүргүүлэх ажлыг хэвшүүлэх. | өдрийн 6/04 дугаартай албан шаардлагад заагдсан Саатуулах байр нь халуун ус байхгүй, цэвэрлэгээ хангалтгүй байна гэсэн зөрчлийг арилгуулахаар аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт баривчлах байрыг халуун усны шугамтай болгох, орон тооны үйлчлэгч ажиллуулах төсвийг шийдвэрлүүлэх саналыг хүргүүлсэн тухай хариу мэдэгдэн, шаардлагад дурьдсан зөрчлийг дотооддоо шийдвэрлэн, халуун усны халаагч тавьж, хүмүүжигч нараар хуваарийн дагуу тогтмол цэвэрлэгээ хийлгэж хэвшээд байна.<br>2016 оны 03 дугаар сарын 04-ний өдөр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.2 дахь хэсэгт зааснаар эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан 2016140000118 дугаартай хэргийг 2016 оны 07 дугаар сарын 03-ны өдөр ердийн журмаар 1-р хугацаа сунган, мөрдөн байцаалтын хугацааг 15 хоногоор тогтоосон бөгөөд мөрдөн байцаагч эрүүгийн хэргийг хүлээн аваад тогтоосон хугацаанд ямарч ажиллагаа хийгээгүй дарагдуулсан, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.11 дэх хэсэгт заасныг зөрчсөн.<br>Мөрдөн байцаагч, цагдаагийн ахмад Б.Ганхуягт 21641014 дугаартай албаны шалгалт явуулсан Цагдаагийн газрын даргын 2016 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн Б/78 дугаар тушаалаар сануулах сахилгын шийтгэл оногдуулж, 2016 оны 09 дүгээр сарын 22-нд 40/04/2471 дугаартай албан бичгээр хариу өгсөн.<br>Мөрдөн байцаагч, цагдаагийн ахмад Б.Мандухай нь эрүүгийн 201614000309 дугаартай хэрэгт хүлээн авах тогтоол үйлдээгүй, холбогдох ажиллагаа хийгээгүйгээр дарагдуулж, 2016 оны 08 дугаар сарын 12-нд мөрдөн байцаалтын хугацаа сунгуулахаар ирүүлсэн, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 182 дугаар зүйлийн 182.7 дахь заалтын зөрчсөн, мөрдөн байцаагч, цагдаагийн ахмад Б.Мөнхтулга нь 2016 оны 06 дугаар сарын 30-ны өдөр Эрүүгийн хуулийн 95 дугаар зүйлийн 95.1 дэх хэсэгт зааснаар эрүүгийн хэрэг үүсгэсэн 201614000335 дугаартай хэрэгт нэн даруй хийх ажиллагаануудыг хийлгүй хугацаа алдсан. Эрүүгийн 201614000303 дугаартай хэрэгт прокурорын даалгаварт заагдсан ажиллагааг дутуу хийж, хэргийг 2016 оны 08 дугаар сарын 11-ний өдөр түдгэлзүүлэх санал үйлдэж, прокурорын хяналтанд ирүүлсэн, мөрдөн байцаагч, цагдаагийн ахмад Б.Ганхуяг нь эрүүгийн 201614000274 дугаартай хэргийг 2016 оны 07 дугаар сарын 24-ний өдөр түдгэлзүүлэх санал үйлдэж, батлуулсан боловч прокурорын хяналтанд 2016 оны 08 дугаар сарын 08-ны өдөр ирүүлсэн. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 205 дугаар зүйлийн 205.3 дахь хэсэгт заасныг зөрчсөн, мөрдөн байцаагч, цагдаагийн ахмад Б.Мандухайд  сарын үндсэн цалинг 1 сар 10 хувь, цагдаагийн ахмад Б.Мөнхтулга, Б.Ганхуяг нарыг 1 сар 20 хувь хасах шийтгэл оногдуулж, 2016 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 40/04/2517 тоот албан бичгээр хариу хүргүүлсэн.<br>Мөрдөн байцаагч, цагдаагийн ахмад Б.Ганхуяг нь эрүүгийн 201614000246 дугаартай хэрэгт Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.12 дахь хэсэгт заасныг зөрчиж, прокурорын даалгаварт заагдсан ажиллагааг явуулаагүй. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 182 дугаар зүйлийн 182.7 дахь хэсэгт заасныг зөрчиж, 5 хоног хугацаа алдсан тул 21644020 дугаартай албаны шалгалт явуулж, Цагдаагийн газрын даргын 2016 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн Б/110 дугаар тушаалаар үндсэн цалинг 1 сар 20 хувь хасах сахилгын шийтгэл оногдуулж, 2016 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 40/04/4256 дугаартай албан бичгээр хариу хүргүүлсэн.<br>2016 онд тус Цагдаагийн газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасаг нь нийт 3 шаардлага хүлээн авч, шалтгааныг судлахад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар нь хэргийн хугацааг сунгуулахгүй хугацаа алдах, эрүүгийн хэргийг хугацаа алдаж прокурорт шилжүүлэх, прокурорын бичсэн даалгаврын заалтыг бүрэн хангахгүй хэргийг шилжүүлсэн зөрчлүүд ээзлж байна. Үүнтэй холбогдуулан алба хаагч нарт аймгийн Прокурорын газрын орлогч прокурор С.Ёндонсамбуутай хамтран 3 удаа нийт 6 цагийн сургалт зохион явуулсан.<br>Мөн Цагдаагийн газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасгийн даргаас прокурорын шаардлагад дурьдагдсан зөрчлийн талаар алба хаагч нарт мэдээлэл хийн, албан даалгавар өгч, алба хаагчдаас гаргаж байгаа нийтлэг алдаа зөрчлийг арилгах, тавих хяналтыг сайжруулсанаар 2016 оны 4 дүгээр улиралд прокурорын шаардлага аваагүй байна.<br>Зөрчил гаргасан мөрдөн байцаагч, цагдаагийн ахмад Б.Мандухай, цагдаагийн ахмад Б.Мөнхтулга, цагдаагийн ахмад Б.Ганхуяг, цагдаагийн дэслэгч Г.Эрдэнэбаяр нарын гар дээр шалгагдаж байгаа нийт 32 эрүүгийн хэрэгтэй танилцаж, давхардсан тоогоор 35 даргын даалгавар бичиж, биелэлтэнд нь хяналт тавьж ажилласан байна.<br>Хэрэг бүргэгч, мөрдөн байцаагч нарын гар дээр шалгагдаж байгаа гомдол мэдээлэл, эрүүгийн хэргийг уншиж танилцан, нийт 152 даалгавар бичиж, биелэлтийг тооцон ажилласан байна.<br>Аймгийн Прокурорын газартай сар болгоны эхний 7 хоногт хамтарсан зөвлөгөөнийг зохион байгуулж, мөрдөн байцаагч нарын гар дээр шалгадаж байгаа удааширсан, хугацаа сунган шалгагдаж байгаа нийт 7 хэргийг зөвлөгөөнөөр хэлэлцүүлэн шийдвэрлэсэн байна. Мөн аймгийн Прокурорын газартай хамтран сар бүр шийдвэрлэх хэргийн график гарган, үр дүнг тооцож ажилласан. | | |
| | 30 | 3.3.9. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2007 оны | 2016 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 09:00-17:00 цагийн хооронд Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг иргэд олон нийтэд | 100% | 5 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 97 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 190 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Цагдаагийн газрын хэмжээнд “Нээлттэй хаалганы өдөр" арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тооцох. | сурталчилах, цагдаагийн мэргэжлийн албадуудын үйлчилгээг хүртээмжтэй хүргэх зорилгоор "Амар тайван амьдралын төлөө хамтдаа" уриан дор зохион байгуулагдсан "Нээлттэй хаалганы өдөрлөг"-т оролцож, хэлтсийн алба үйл ажиллагаагаа ард иргэдэд сурталчилсан.<br>2016 оны 10 дугаар сарын 14-ний өдөр Эрдэнэт үйлдвэрийн Захиргаа аж ахуйн байранд тасгийн нээлттэй хаалганы өдөрлөгийг явуулж, хэлтсийн үйл ажиллагааг сурталчилж, иргэд, ажилчдаас гаргасан асуултанд зөвлөмж, хариулт өгч, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль”, зөрчилд оногдуулахаар заасан арга хэмжээний талаарх мэдээллийг агуулсан гарын авлага, материал тараасан.<br>Цагдаагийн газрын үйл ажиллагаа, ãýì ò õýðãýýñ óðüä÷èëàí ñýðãèéëýõ àæëûí òàëààð, аймгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын мэдээг иргэд олон нийтэд мэдээллэх зорилгоор www.police.or.gov.mn цахим хуудас болон facebook хаягаар тогтмол мэдээлэл хийн, иргэдэд сурталчилахаас гадна орон нутгийн 3 телевизтэй хамтран 2016 онд хамтран ажиллах гэрээ байгуулан aæèëëàæ байна.<br>2016 îíû 03 дугаар ñàðûí 21-íий ºäºð àéìãèéí Уурхайчин соёлын ордонд Öàãäààãèéí ãàçðûí Íийтийн хэв журам хамгаалах тàñãààñ “Нээлттэй хаалганы ºäºð”-èéã çîõèîí áàéãóóëæ, èðãýäýä үйл ажиллагаагаа òàíèóëàí ñóðòàë÷иëàõ çîðèëãîîð çîõèîí áàéãóóëàí, иргэдээс санал хүсэлтийг сонсож ажилласан.<br>Цагдаагийн байгууллага үүсч хөгжсөний 95 жилийн ой, Орхон аймаг дахь Цагдаагийн газар байгуулагдсаны 40 жилийн ойг угтан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2007 оны 97 дугаар зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор “Нээлттэй хаалганы өдөр”-ийг 2016 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 09 цагаас 17 цаг хүртэл Орхон аймгийн “Уурхайчин соёлын ордон”-д “Амар тайван амьдралын төлөө” уриан дор зохион байгууллаа. Өдөрлөгт Орхон аймаг дахь Цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах тасаг, Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасаг, Замын цагдаагийн тасаг, “Эрдэнэт үйлдвэр” ХХК дахь Гэрээт цагдаагийн хэлтэс, Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгаас тасаг бүрийн онцлогийг харуулсан үзүүлэн, тараах материал бэлтгэн иргэдэд сурталчилж, хөтөлбөрийн хүрээнд зохион явуулж буй үйл ажиллагааны талаар зөвлөгөө өгч, сурталчилах хэлбэрээр зохион байгуулсан.<br>Орхон аймаг дахь Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгаас иргэд олон нийтэд тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн лавлагаа 57, жолоодох эрх дуусгавар болсон 8 иргэний материалыг хүлээн авч, тээврийн хэрэгсэл жолоодох эрх сэргээх, хууль эрх зүйн зөвлөгөө, жолоочийн зөрчлийн бүртгэлийн оноо тооцох журмын талаар 200 ширхэг нугалбарыг хийн иргэдэд тарааж, замын хөдөлгөөнд оролцож | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | буй тээврийн хэрэгсэлтэй болон явганаар хөдөлгөөнд оролцож буй иргэдэд замын хөдөлгөөний хуулийг баримтлан, өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангаж оролцох талаар 120 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Өдөрлөгийн үеэр Орхон аймгийн Баян-Өндөр сумын 8 цэцэрлэгийн хүүхэд багачуудын дунд “Ногоон гэрэл, цагаан шугам” тэмцээний эхний 3 байранд орсон цэцэрлэгийн хүүхдүүдийн үзүүлэх тоглолтыг иргэдэд үзүүлж сонирхуулсан.<br>Тус газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгаас гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргийн талаар Монгол Улсын Их сургуулийн Орхон сургууль, Орхон мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, ерөнхий боловсролын 12 сургуулийн сурагч, оюутнуудад зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан.<br>Гэмт хэргээс урьлдчилан сэргийлэх чиглэлээр өдөрлөгт оролцсон Дулааны цахилгаан станцын 80 ажилтан, Хивсний үйлдвэрийн 120 ажилтан, “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн 220 ажилтан, нийт 520 гаруй иргэдэд зөвлөгөө өгч, мэдээ, мэдээллээр ханган, сэрэмжлүүлэг тарааж ажилласан байна.<br>Галт зэвсгийн гэрчилгээ олгох, сургалтанд хамрагдах талаар 24 иргэнд зөвлөгөө өгч ажилласан байна.<br>Мөн тус Цагдаагийн газарт ашиглагдаж байгаа техник хэрэгсэл, автомашинуудыг болон цагдаагийн алба хаагчийн шинээр батлагдсан дүрэмт хувцасны талаар үзүүлэн бэлтгэж, иргэдэд сонирхуулан, мэдээлэл хийж ажилласан.<br>“Нээлттэй хаалганы өдөр”-ийн талаар иргэдэд сурталчилах, хийж байгаа ажлын талаар иргэдэд хүргэх, иргэдийг татан оролцуулах зорилгоор орон нутгийн мэдээлийн хэрэгсэл болох “Номин”, “MBS”, “Тусгал”, “EBS”, “Сонор”, “ТҮ-10”, “Лха” телевизүүдэд Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа Б.Даваазул, Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн хурандаа Р.Болдбаатар, Олон нийттэй харилцах ажил хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн ахмад Н.Батнасан, Замын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч М.Баттулга нар ярилцлага өгч, шууд нэвтрүүлэг бэлтгэн иргэдийн санал хүсэлтийг сонсож, үйл ажиллагаагаа сурталчилан ажилласан. Өдөрлөгийн үеэр иргэдээс 112 санал, хүсэлт хүлээн авч, газар дээр нь шийдвэрлэн хариу өгч, эргэж хариу мэдэгдэх, гарсан санал хүсэлтийн мөрөөр шалгалтын ажиллагаа явуулах зэргээр санал хүсэлтийг шийдвэрлэн ажилласан.<br>Тус Цагдаагийн газраас 2016 оны 08 дугаар сарын 25-ны өдөр Гэр хорооллын цагдаагийн хэсэгт “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион явуулсан бөгөөд уг арга хэмжээний үеэр иргэдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын талаар болон Цагдаагийн байгууллагын бүтэц, орон | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | тоо, үйл ажиллагааны талаар танилцуулан, Цагдаагийн газрын алба хаагч нарын урлагийн тоглолтыг зохион байгуулж иргэдэд сонирхуулсан. Аймгийн хэмжээнд хууль хяналтын байгууллагуудын “Нээлттэй хаалга”-ны өдөрлөгийн 4 дүгээр улирлын зохион байгуулах хугацаа 2016 оны 12 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулахаар төлөвлөгөө гарсан бөгөөд тус Цагдаагийн газраас өдөрлөгийн үед ажиллах тасаг, албадын үйл ажиллагаа, оролцох алба хаагч нарыг томилон, бэлтгэл ажил хангагдаад байна. | | |
| **Дөрөв "Эрүүл чадварлаг хүний нөөц бүрдүүлэх" гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ** | | | | | |
| 4.1.Хүний нөөц, сургалт, соён гэгээрүүлэх ажлын үр дүнг дээшлүүлэх талаар | 31 | 4.1.8. Албан үүргээ гүйцэтгэж яваад амь үрэгдсэн Г.Дунгар агсаны эргэн дурсаж мөнхжүүлэх "Бид мартахгүй" өдөрлөг зохион байгуулах. | 1987 оны 12 дугаар сарын 20-ны өдөр албан үүргээ гүйцэтгэж байгаад амь насаа алдсан тус Цагдаагийн газрын хэв журмын цагдаа асан Гомбожав овогтой Дунгарын алдрыг мөнхжүүлэн, “Бид мартахгүй” өдөрлөгийг байгууллагын хэмжээнд зохион байгуулав. Өдөрлөгийн арга тусгай хөтөлбөр төлөвлөгөөний дагуу Орхон аймгийн “Уурхайчин соёлын ордон”-д зохион байгуулж, Цагдаагийн газрын Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Д.Мөнхбат нийт бие бүрэлдэхүүнд Г.Дунгарын ажил үйлсийн талаар мэдээлэл хийж, түүний хүү Д.Одбаярт 100.000 төгрөг, үнэ бүхий зүйлийн буцалтгүй тусламж олгосон байна. | 100% | 5 |
| | 32 | 4.1.9. Байгууллагаас чөлөөнд гарсан ахмадуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах. | Монголын уламжлалт цагаан сарын бичин жилийг тохиолдуулан тус байгууллагаас цэргийн алба хаасны тэтгэвэрт гарсан ахмад ажилтнуудыг хүлээн авч, хүндэтгэл үзүүлэх ажиллагааг 2016 оны 02 дугаар сарын 18-ны өдөр тус Цагдаагийн газрын “Хангайн бүс” сургалтын танхимд зохион байгуулж, 1.948.000 төгрөгийг зарцуулсан. Мөн Монголын “Ахмадын баярын өдөр”-ийг тохиолдуулан 2016 оны 10 дугаар сарын 02-ны өдөр Цагдаагийн байгууллагаас цэргийн алба хаасны тэтгэвэрт гарсан тус газарт бүртгэлтэй ахмад ажилтнуудад хүндэтгэл үзүүлэх ажлыг Цагдаагийн газраас “Амралтын газар” дээр зохион байгуулж, уг арга хэмжээнд туслах аж ахуйгаас 2 хонь, 300.000 төгрөгийг зарцуулсан байна. | 100% | 5 |
| 4.2 Алба хаагчдын нийгмийн баталгааг хангах, ажил, үүрэг гүйцэтгэх нөхцөл боломжийг бүрдүүлэх талаар | 33 | 4.2.3. Алба хаагчдыг орон сууцны хөнгөлттэй зээлд хамруулах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулах. | Цагдаагийн газрын алба хаагчдаас орон сууцны хөнгөлөлттэй зээл хамрагдах хүсэлт гаргасан 148 алба хаагчдын судалгаа гарган, Засгийн газраас хөнгөлөлттэй нөхцөлөөр олгогдох ипотекийн 5 хувийн зээлд хамрагдах алба хаагчдын материалыг Төрийн банктай хамтран нөхцөл хангасан алба хаагчдад зээлийг олгуулахаар ажиллаж байна. Мөн Орхон аймаг Баян-Өндөр сумын Дэнж багт байрлах “Баян-Өндөр” хотхонтой хамтран ажиллахаар хэлэлцээр хийн, зах зээлд 1м$^2$–ын үнэлгээ 1.600.000 төгрөгөөр худалдаж байгаа орон сууцыг Цагдаагийн газрын алба хаагчдад 1.350.000 төгрөг болгон бууруулсанаар алба хаагч захиалга өгөн, гэрээгээ байгуулаад байна. | 80% | 4 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Цагдаагийн ерөнхий газраас Улаанбаатар хот Баянзүрх дүүрэгт алба хаагчдад хөнгөлөлттэй үнээр баригдах орон сууцанд хамрагдахаар 5 алба хаагчдын нэрсийг Цагдаагийн ерөнхий газрын Санхүү хангамжийн газарт хүргүүлж ажилласан.<br>Худалдаа хөгжлийн банк, Төрийн банк, Хаан банктай хамтран ажиллах гэрээний дагуу Монгол Улсын Засгийн газраас олгож буй 5 хувийн зээлд хамрагдах хүсэлт гаргасан алба хаагчдын материалыг хурдан шуурхай судлуулж, зээлийг олгох ажлыг зохион байгуулан ажиллаж байна. | | |
| | 34 | 4.2.6. Алба хаагчдыг гэнэтийн ослын даатгалд хамруулах ажлыг зохион байгуулах. | Цагдаагийн газрын төсвийн 176 алба хаагч, гэрээт 220 алба хаагч, нийт 396 алба хаагчдыг “МИГ даатгал”-ын гэнэтийн ослын даатгалд Цагдаагийн ерөнхий газраас 100 хувь бүрэн даатгуулж ажилласан. МИГ даатгалын Эрдэнэт салбарын даатгалын мэргэжилтэн алба хаагч бүрт сургалт орж, мэдээллийг хүргэсэн.<br>Цаашид гэрээний нөхцөл шалгуурыг хангасан алба хаагчдад зах зээлийн үнэлгээнээс доогуур үнэлгээ санал болгож байгаа барилгын компаниудтай хамтран ажиллахаар төлөвлөж байна. | 100% | 5 |
| **Тав. “Үр ашиггай төсөв, санхүү, хөрөнгө оруулалт” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ** | | | | | |
| 5.1 Төсвийг үр ашигтай зарцуулах талаар | 35 | 5.1.2. Шилэн дансны тухай Монгол Улсын хуулийн хэрэгжилтиег хангах ажлыг зохион байгуулж, хяналт тавих. | Тус Цагдаагийн газар нь 2015 оноос эхлэн шилэн дансны мэдээллийг шилэн дансны мэдээлэл оруулах албан тушаалтан томилон ажиллуулж, байгууллагын санхүүгийн мэдээллийг сар, улирал, хагас, бүтэн жилээр оруулж ажилласан.<br>2016 онд нийт 123 мэдээ мэдээллийг бүртгэж цахим хуудсанд байршуулсан.<br>Төсвийн гүйцэтгэл, зарцуулалтыг сар бүрийн 01-ний дотор гаргаж, цахим болон цаасан самбарт байршуулан, иргэд болон алба хаагчдыг санхүүгийн тайланд хяналт тавих боломжийг хангаж ажиллаж байна. Мөн цахим хуудсанд байршуулан ажиллахад иргэд, алба хаагчдаас санал, дүгнэлт ирээгүй ба ил тод байршуулсанд сайшаасан сэтгэгдэл 3 ирсэн. Дээрхи оруулсан мэдээ, мэдээллийг цаасан хэлбэрээр бүртгэж бааз үүсгэн, удирдлагад танилцуулан, хяналтыг тавиулан ажиллаж байна. | 90% | 4,5 |
| | 36 | 5.1.5. Төсвийн хөрөнгө оруулалтаар Жаргалант суманд хуваарийн дагуу цагдаагийн бичил хэсгийн байр /Кобан/ бариулах ажлыг зохион байгуулах, барилгын гүйцэтгэлд хяналт тавих. | Орхон аймаг дахь Цагдаагийн газрын даргын 2016 оны 2 дугаар сарын 05-ны өдрийн А/10 дугаартай “Үнэлгээний хороо байгуулах тухай” тушаалын дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Орхон аймгийн Жаргалант суманд “Хэсгийн төлөөлөгчийн ажлын байр /кобан/” барих тендерийн БА-2016/01 дугаар төсөлд “Эвсэг алтай констракшн” ХХК нь шалгаран, нийт 79,954,619 төгрөгөөр Орхон аймгийн Жаргалант суманд “Хэсгийн төлөөлөгчийн ажлын байр /кобан/” барьж байгуулах ажлыг зохион байгуулахад хяналт тавьж ажилд | 100% | 5 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | оруулсан.<br>Барилга барих ажилд газрын удирдлага, аж ахуйн ажилтан, нярав, нягтлан бодогч, хэсгийн төлөөлөгч, сумын Засаг даргын орлогч зэрэг албан тушаалтан нар гүйцэтгэлд нийт 5 удаа хяналт тавьж, гадна пасатны өнгө, чанар зэрэгт санал тавьж, солиулсан. | | |
| | 37 | 5.1.8. Тус Цагдаагийн газрын алба хаагч нэг бүрийн хувцасны размерийг нарийвчлан шинэчлэн тогтоох ажлыг зохион байгуулах. | Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, хангамжийн газрын Хангалт үйлчилгээний төвтэй хамтран тус Цагдаагийн газар ажиллаж байгаа төсвийн 162, “Эрдэнэт үйлдвэр” ХХК дахь Гэрээт цагдаагийн хэлтсийн нийт 216 алба хаагчдын албаны дүрэмт хувцасны ерөнхий, малгайн, цамцны, гутлын хэмжээсүүд болон биеийн өндөр, жин, цээж, бэлхүүс, өгзөгний тойргийг нэг бүрчлэн авч, хавсралт материалыг Хангалт үйлчилгээний төвд хүргүүлсэн. | 100% | 5 |
| **Зургаа. “Олон нийттэй /үйлчлүүлэгч, хэрэглэгч/ харилцах" гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ** | | | | | |
| 6.1.Олон нийт-цагдаагиин Хамтын ажиллагааг өргөжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг дээшлүүлэх талаар | 38 | 6.1.1. Тус аймгийн хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн мэдээ, судалгаанд дүгнэлт хийж, тэдгээрийг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцлийн үндсэн дээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион явуулах. | Аймгийн хэмжээнд 2015 онд өсөлттэй байгаа гэмт хэргийн талаар судлагаа гарган, Баян-Өндөр сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн хурлаар 2016 онд хийж гүйцэтгэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын салбар төлөвлөгөөг гарган хэлэлцэж, 2016 оныг “Нохойг эзэнжүүлж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх жил” болгон зарлаж, нохойд уруулж гэмтсэн, хазуулсан Цагдаагийн газарт бүртгэгдсэн гэмт хэргийн талаар мэдээлэл оруулан хэлэлцүүлж, аймгийн 22 багийн Засаг дарга нарт Эрүүгийн хуулийн 201 дүгээр зүйл буюу “Орчиндоо аюул учруулах амьтныг зохих хамгаалалтгүй байлгах” гэмт хэргийн талаар сургалт зохион байгуулан, иргэдэд энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор сэрэмжлүүлэг тараан ажиллаж, www.police.or.gov.mn цахим хуудас болон facebook хаягаар сурталчилан ажилласан.<br>Хүүхдийн байцаагч нар сар бүр гэмт хэрэг, зөрчил гардаг сургуулиудын судалгааг гаргаж, сургуулийн захирлуудын нэр дээр Монгол улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу гэмт хэрэг, зөрчлийг арилгах, цаашид урьдчилан сэргийлэх чиглэлээр ажил зохион байгуулах, дахин гэмт хэрэг, зөрчил гаргахгүй байх талаар хамтран ажиллаж байгаа ба сургуулиудын зоритлот бүлгийн хүүхдүүдийн судалгааг сургуулиас гаргуулан авч, тэдэнд чиглэсэн сургалтыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна.<br>Цагдаагийн газраас гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгдэж байгаа газар, түүний дотроос ерөнхий боловсролын сургуулиудын судалгааг сар бүр гарган, дээрхи гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор эргүүлийн маршрутыг оновчтой зохион байгуулан, сургуулийн ойр орчимд Олон нийтийн цагдаагийн ажилтан нарыг томилон ажиллуулж байна. | 90% | 4,5 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Цагдаагийн газраас аймгийн хэмжээнд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн судалгааг гарган, хууль хяналтын байгууллага, аймгийн Засаг даргын тамгын газар болон багийн Засаг дарга, нийгмийн ажилтан нарын хамтарсан зөвлөгөөнийг аймгийн Засаг даргын тамгын газарт зохион байгуулан, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилан ажилласан бөгөөд уг зөвлөгөөнд 22 багийн Засаг дарга, нийгмийн ажилтан, Олон нийтийн цагдаагийн ажилтан зэрэг 56 хүн оролцсон байна.<br>Цагдаагийн газраас ерөнхий боловсролын сургуулийн бүлгэмүдийн үйл ажиллагааг идэвхижүүлэх, хамтран ажиллах, сурагчдын дундаас гэмт хэрэг, зөрчил холбогдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор 2016 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр “Хүүхдийн ордонд” аймгийн хэмжээнд ажиллаж байгаа нийт бүлгэмүүдийн сурагчдыг, сургуулийн нийгмийн ажилтан нартай хамт цуглуулан яриа хийж, нөхцөл байдлаа танилцуулан, багийн хэсгийн байцаагч, Олон нийтийн цагдаагийн ажилтан нартай ажиллуулахаар баг болгон хуваарилан ажиллаж байна.<br>Аймгийн хэмжээнд үйлдэгдэж байгаа өсөлттэй гэмт хэргийг бууруулах ялангуяа гудамж талбайд үйлдэгдэж байгаа ãýì ò õýðãèéã áóóðóóëàõ, óðüä÷èëàí ñýðãèéëýõ çîðèëãîîð îðîí íóòãèéí Номин òåëåâèçòýé õàì òðàí øóóä íýâòð¿¿ëãý¿¿äèéã зохион явуулж, “Дуудлага” íýâòð¿¿ëэгийг сард 2 удаа нийт 12 удаа çîõèîí ÿâóóëсан. | | |
| | 39 | 6.1.2. Цагдаагийн газрын хэмжээнд хэрэгжих гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг хангах. | Цагдаагийн ерөнхий газрын даргын 2016 оны 03 дугаар сарын 30-ны өдөр баталсан 2016 онд хэрэгжүүлэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Цагдаагийн газрын салбар төлөвлөгөөг боловсруулан, хэлтэс, тасгуудад хуваарилан өгч, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.<br>Баян-Өндөр сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн хурлаар 2016 онд хийж гүйцэтгэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын салбар төлөвлөгөөг гарган хэлэлцэж, 2016 оныг “Нохойг эзэнжүүлж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх жил” болгон зарлаж, нохойд уруулж гэмтсэн, хазуулсан Цагдаагийн газарт бүртгэгдсэн гэмт хэргийн талаар мэдээлэл оруулан хэлэлцүүлж, аймгийн 22 багийн Засаг дарга нарт Эрүүгийн хуулийн 201 дүгээр зүйл буюу “Орчиндоо аюул учруулах амьтныг зохих хамгаалалтгүй байлгах” гэмт хэргийн талаар сургалт зохион байгуулан, иргэдэд энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор сэрэмжлүүлэг тараан ажиллаж, www.police.or.gov.mn цахим хуудас болон facebook хаягаар сурталчилан ажилласан.<br>Шинэчлэгдэн батлагдсан Цагдаагийн албаны тухай хуулиар Цагдаагийн газрын нийт алба хаагчдад 7 хоног бүрийн 3 дахь өдөр зохион байгуулагддаг сургалтын цагаар нийт 24 удаа сургалт орсон. | 90% | 4,5 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Мөн шинээр батлагдсан хууль тогтоомжийг иргэд олон нийтэд хүртээмжтэй мэдээлэх, сурталчилах зорилгоор www.police.or.gov.mn цахим хуудсанд байршуулж, иргэдэд хууль тогтоомжийг сурталчилан ажиллаж байна.<br>Орон нутгийн “Номин” телевизийн “Хуулийн цаг” нэвтрүүлэгт 3 удаа оролцон, шинээр батлагдсан хууль тогтоомжийн талаар болон Цагдаагийн байгууллагын бүтэц өөрчлөлтийн талаар иргэдийн сонирхсон асуултанд хариулж оролцсон.<br>Цагдаагийн ерөнхий газрын даргын 2016 оны 05 дугаар сарын 06-ны өдөр баталсан “Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд инноваци нэвтрүүлэх нь” сэдэвт Хангайн бүсийн эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөнийг бүсчилсэн хэлбэрээр 2016 оны 05 дугаар сарын 23-ны өдөр Орхон аймаг дахь Цагдаагийн газрын хурлын зааланд зохион байгуулсан. Тус зөвлөгөөнд Хөвсгөл аймгаас 1, Архангай аймгаас 2, Дархан-Уул аймгаас 4, Сэлэнгэ аймгаас 1, Булган аймгаас 5, Орхон аймгаас 6 нийт 20 хүн оролцон илтгэл тавьсан. Илтгэлийн үйл ажиллагаа амжилттай зохион байгуулагдсан бөгөөд тухайн илтгэлүүдийг цахим хэлбэрээр Цагдаагийн ерөнхий газрын Гэмт хэрэгтэй тэмцэх албанд хүргүүлж ажилласан. Дээрхи зөвлөгөөнд Булган аймгаас иргэний нийгмийн байгууллагыг төлөөлөн 1 иргэн, Орхон аймгаас Монгол Улсын Их Сургуулийн Орхон салбар сургуулийн 4 дүгээр курсын оюутан Н.Дөлгөөн нар өөр өөрсдийн илтгэлийг амжилттай бэлтгэж оролцсон.<br>Ерөнхий боловсролын сургуулиуд дээр үйл ажиллагаа явуулж байгаа хүүхдийн өөрсдийгөө хөгжүүлэх сайн дурын бүлгэмийн 6000 орчим хүүхдүүдээс бусаддаа нөлөөлж, үлгэр дууриал болохуйц сурагчдыг сургууль бүрээс нэг сурагчийг сонгон авч, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтэнтэй хамтран үе тэнгийнхэн дотроо хууль, эрх зүйн мэдлэг олгох, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр багш бэлтгэх ажлыг хийж эхлээд байна.<br>Олон нийт цагдаагийн хамтын ажиллагааг өргөжүүлэх ажлын хүрээнд 22 багийн Засаг дарга, нийгмийн ажилтан нартай хамтран архины хамаарал бүхий иргэдийг цуглуулан, “Аминчхан яриа” Төрийн бус байгууллагатай хамтран 5 хоногийн сургалтыг Цагдаагийн газарт зохион явуулж, нийт 120 гаруй иргэдийг хамруулан ажиллаж, орон нутгийн мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн.<br>Цагдаагийн газрààñ ãýì ò õýðãýýñ óðüä÷èëàí ñýðãèéëýõ àæëûí òàëààð, аймгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын мэдээг иргэд олон нийтэд мэдээлэх зорилгоор www.police.or.gov.mn цахим хуудсанд тогтмол байршуулж, иргэдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр орон нутгийн 7 телевиз, 4 ФМ радио, 2 сонинтой хамтран сурталчилахаас гадна хэвлэмэл зурагт хуудас, санамж, | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | сэрэмжлүүлэг 3200 ширхэгийг тарааж àæèëëàсан.<br>Цагдаагийн газарт биечлэн ирж үйлчлүүлж байгаа иргэдэд Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа болон гэмт хэрэг, зөрчлийн мэдээ, иргэд олон нийтэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, цаг үеийн нөхцөл байдлын зарлан мэдээлэл, ил тод байдлыг хангах зорилго бүхий мэдээллийн урсдаг электрон самбараар иргэдэд тогтмол мэдээлэл өгч ажиллаж байна.<br>Мөн Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код 101, 134/-д заасан мэдээллийн ил тод байдлыг хангах, Цагдаагийн байгууллагаар үйлчлүүлж буй иргэдэд мэдээ, мэдээлэл өгөх мэдээллийн Smart touch таблом болон иргэдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгаа хүргэх зорилго бүхий мэдээллийн табломыг суурилуулан, мэдээ, мэдээллээр хангаж ажиллаж байна.<br>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр орон нутгийн “Номин” телевизтэй хамтран 7 хоног үрийн Баасан гарагт тухайн сард өсөлттэй байгаа гэмт хэргийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр нэвтрүүлэг бэлтгэн явуулж ажиллаж байна.<br>Нутаг дэвсгэрийн эрүү, хэв журмын нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгч, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой зохион байгуулан ажилласны үр дүнд аймгийн хэмжээнд үйлдэгдсэн нийт гэмт хэрэг 2016 оны 11 дүгээр сарын байдлаар 5,7 хувиар, гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 7,4 хувиар, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 15,7 хувиар, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 4.6 хувиар, хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг хэрэг 56,4 хувиар, согтуугаар үйлдэгдсэн хэрэг 4,6 хувиар, бусдын бие махбодид гэмтэл учруулах хэрэг 6.5 хувиар, малын хулгайн хэрэг 23 хувиар, булаах хэрэг 60 хувиар тус тус буурч, гэмт хэргийн илрүүлэлт 66,5 хувьд хүрсэн. | | |
| 40 | 6.1.3. Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 252 дугаар тогтоолоор батлагдсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл сурталчилгааны хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтиг хангах ажлыг эрчимжүүлж, үр дүнг тооцох. | Цагдаагийн газраас хууль òî ãòîîì æèéí òàëààð îðîí íóòãèéí ìýäýýëëèéí õýðýãñëýýð áîëîí öàõèì ààð, www.police.or.gov.mn цахим хуудас болон facebook хаÿãààð èðãýäýä ìýäýýëýí àæèëëàæ, áàéãóóëëàãà, àæ àõóéí íýãæ¿¿äýä Çàñãèéí ãàçðûí 2012-2016 онд хэрэгжүүлэх “Олон íèéò-цагдаагийн хамтын ажиллагаа” хөтөлбөр, “Гэмт хэргээс урьдчилан ñýðãèéëýõ ìýäýýëýë ñóðòàë÷èëãààíû õºòºëáºð”-¿¿äèéã îðîí íóòàãò õýðýãæ¿¿ëýõ àæëûã çîõèîí áàéãóóëàí àæèëëàæ áàéíà.<br>Цагдаагийн газрын үүдэнд байрлах дэлгэцээр мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгийн талаар мэдээллийг тогтмол нэвтрүүлэн, иргэдэд хүргэж байна.<br>2016 оны аймгийн Засаг даргын үндсэн чиглэлийн төлөвлөгөөнд хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын талаарх мэдээллийг иргэдээс төлбөртэй авах, үүрэн телефоны оператор компаниудтай | 90% | 4,5 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | хамтран гар утсаар мэдээллийг авах ажилд зарцуулах 1.200.000 мянган төгрөгийг төсөвлөн хүргүүлсэн бөгөөд эдийн засгийн хүндрэлтэй байдлаас болоод шийдвэрлэгдээгүй байна.<br>Хүүхдийн байцаагч сар бүр гэмт хэрэг, зөрчил гардаг сургуулиудын судалгааг гаргаж, сургуулийн захирлуудын нэр дээр Монгол Улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу гэмт хэрэг, зөрчлийг арилгах, цаашид урьдчилан сэргийлэх чиглэлээр ажил зохион байгуулах, дахин гэмт хэрэг, зөрчил гаргахгүй байх талаар хамтран ажиллаж байгаа ба сургуулиудын зорилтот бүлгийн хүүхдүүдийн судалгааг сургуулиас гаргуулан авч, тэдэнд чиглэсэн сургалтыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна.<br>Цагдаагийн газраас гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгдэж байгаа газар түүний дотроос ерөнхий боловсролын сургуулиудын судалгааг сар бүр гарган, дээрхи гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор эргүүлийн маршрутыг оновчтой зохион байгуулж, сургуулийн ойр орчимд Олон нийтийн цагдаагийн ажилтан нарыг томилон ажиллуулж байна.<br>“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн ажилчдын дунд архидан согтуурах явдал их байгаатай холбогдуулан “Ажилчдын дунд архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөө”-г сар бүр гаргаж, “Архины зөрчилгүй хамт олон аян”-ыг зохион байгуулж, аяны хүрээнд 82 албан мэдэгдэл, сэрэмжлүүлэг бичиж тараан, 26 сургалт зохион байгуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр 72 удаа сурталчилан ажилласан.<br>Мөн аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудын дунд “Архи-тамхигүй ирээдүй” болзолт уралдааныг зарлаж, нэгдсэн арга хэмжээний хүрээнд хагас, бүтэн жилээр ажлыг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, шалгарсан байгууллага, аж ахуйн нэгжүүдийг шагнаж урамшуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.<br>Мансууруулагч, донтуулагч бодисын талаар иргэдэд урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох талаар мэргэжлийн хяналтын байгууллагуудтай хамтран мэдээлэл солилцож ажиллаж байна.<br>Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа томоохон аж ахуйн нэгж, байгууллагуудад “Архи, тамхигүй хамт олон, архи тамхигүй орчинг бүрдүүлсэн хамт олон” болох уриалгыг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлтэй хамтран хүргүүлж, 2016 оны 12 дугаар сард дүгнэхээр ажиллаж байна.<br>Ãýì ò õýðãýýñ óðüä÷èëàí ñýðãèéëýõ, иргэд олон нийтэд хүртээмжтэй мэдээлэх зорилгоор www.police.or.gov.mn цахим хуудас болон facebook хаяг нээн ажиллуулж, иргэдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга замыг телевиз, радио, сонинтой хамтран сурталчилахаас гадна | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хэвлэмэл зурагт хуудас, санамж, сэрэмжлүүлэг, самбар зэргийг гудамж талбайд ил байрлуулах, иргэдэд тараах зэргээр сурталчилàí àæèëëàæ байна.<br>Цагдаагийн газраас хүн худалдаалах болон бусад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Тусгал”, ”Номин” телевизүүдтэй хамтран 2 удаа богино хэмжээний шторк хийлгэж нэвтрүүлсэн. Аймгийн хүн ихээр цуглардаг газар болох Хүрэнбулаг багийн Үйлчилгээний төвийн гадна байрлах Лед дэлгэцээр хүн худалдаалах болон бусад төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, шторкыг тогтмол явуулж, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж байна.<br>Тус Цагдаагийн газраас мансууруулах төрлийн ургамал ургадаг Жаргалант сумын нутагт 2 га газрыг Эрүүгийн цагдаагийн тасгийн алба хаагч нар өөрсдийн хөрөнгөөр устгал хийж, мансууруулах бодисоос урьдчилан срэгийлэх чиглэлээр Жаргалант сумын 154 иргэнд зөвлөгөө өгөн, сэрэмжлүүлэг хуудас 220 ширхэгийг тараан ажиллаж, дээрхи төрлийн гэмт хэргийн талаар иргэдээс төлбөртэй мэдээлэл авах ажиллагааг зохион байгуулсан.<br>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл сурталчилгааны хөтөлбөрийг сурталчилах ажлын хүрээнд Эрүүл мэндийн газрын 22 ажилтанд сургалт зохион явуулж, 2016 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр 10-12 цагийн хооронд тус газрын ажилтнуудтай хамтран Эрүүл мэндийн газрын үүдэнд өдөрлөг зохион явуулсан. Өдөрлөгийн үеэр иргэдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мансууруулах эм, бэлдмэлийн хор уршгийн талаар зөвлөгөө өгөхийн зэрэгцээ архины хор уршиг, архинаас хэрхэн гарах арга замын талаар мэдээлэл өгч ажилласан.<br>Цагдаагийн газраас аймгийн хэмжээнд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн судалгааг гарган, хууль хяналтын байгууллага, аймгийн Засаг даргын тамгын газар болон багийн Засаг дарга, нийгмийн ажилтан нарын хамтарсан зөвлөгөөнийг аймгийн Засаг даргын тамгын газарт зохион байгуулан, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж ажилласан бөгөөд уг зөвлөгөөнд 22 багийн Засаг дарга, нийгмийн ажилтан, Олон нийтийн цагдаагийн ажилтан зэрэг 56 хүн оролцсон байна.<br>Цагдаагийн газраас ерөнхий боловсролын сургуулийн бүлгэмүүдийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, хамтран ажиллах, сурагчдын дундаас гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор 2016 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр Хүүхдийн ордонд аймгийн хэмжээнд ажиллаж байгаа нийт бүлгэмүүдийн сурагчдыг сургуулийн нийгмийн ажилтан нартай хамт цуглуулан яриа хийж, нөхцөл байдлаа танилцуулан, багийн хэсгийн байцаагч, Олон нийтийн цагдаагийн ажилтан нартай ажиллуулахаар баг болгон хуваарилан ажиллаж байна. | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Орхон аймгийн “Гандантэгчинлэн” хийдийн 10 ламаар авто ослоор хохирч, амь насаа алдсан хүмүүст зориулан ном хуруулж, цугларсан хүмүүсээр зул өргөх ажиллагааг зохион явуулж, авто курсүүдийн сонсогч нарыг зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх санамж сэрэмжлүүлэг, уриа лоозон бариулан талбай дээр ажиллуулсан. Зам тээврийн ослын хор хохирлыг олон нийтэд ойлгуулах, таниулах зорилгоор зам тээврийн осолд өртсөн автомашинууд дээр хөдөлгөөнд оролцогч нарт зориулсан уриа лоозон, сэрэмжлүүлэг байршуулсан цуваag хотын төв гудамж, гэр хорооллын төв замуудаар явуулж, ард иргэдэд суртачилсан ажлуудыг зохион байгуулж ажиллалаа. | | |
| 41 | 6.1.4. Орон нутгийн Иргэдийн хурал, Засаг даргад нутаг дэвсгэрийн эрүү, хэв журмын нөхцөл байдал, түүнд нутгийн төр захиргааны байгууллагаас анхаарах асуудлын талаар мэдээлэл оруулж, тодорхой асуудлаар шийдвэр гаргуулан хамтран ажиллаж байх. | Аймгийн Çàñàã äàðãûí  øóóðõàé çº âëºãº º í  äýýð àéì ãèéí  ýð¿¿ãèéí  áî ëî í  õýâ æóðì ûí  í º õöº ë áàéäëûí  òàëààð ì ýäýýэл хийж, Çасаг даргын тамгын газрын Õууль, эрх зүйн хэлтэст 7 хоног бүр гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээг өгч ажиллаæ áàéí à. 2016 î í û  02 дугаар ñàðä õóðàëдсан ðº ñâèéí  õî äî òãî ëî î ð 2016 онд ажиллах 25 Олон нийтийн цагдаагийн ажилтны цалин 164 сая 464 мянган төгрөгийг ø èéä¿¿ёж, үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.<br>Цагдаагийн газраас 2016 оны орон нутгийн төсөвт хэсгийн байцаагч нарын өрөөг Цагдаагийн байгууллагын нэгдсэн сүлжээнд холбох асуудлыг оруулан хэлэлцүүлж, 16 сая төгрөг, бэлэн бус торгуулийн төхөөрөмж худалдан авахад 22 сая төгрөгийг тус тус шийдүүлсэн бөгөөд одоо үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.<br>Иргэдээс гаргасан саналын дийлэнх нь гэрэлтүүлэг болон камержуулах талаар санал гарсаныг Цагдаагийн газраас хүлээн авч, аймгийн хэмжээнд гэрэлтүүлэг, камержуулалт шаардлагатай 193 цэгийн судалгааг гарган, аймгийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хуралд саналаа хүргүүлж, гэрэлтүүлгийн ажил бүрэн шийдэгдэхээр болсон. Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг судалгааны багаас гэр бүлийн хүчирхийллийн эсрэг сурталчилгааны материал хэвлүүлэхэд шаардагдах 1.500.000 төгрөгийн хөрөнгийн судалгааг гарган өгч шийдүүлсэн бөгөөд 500 ширхэг сурталчилгааны материал хэвлүүлж тараасан.<br>Зам тээврийн гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний дүрмийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор 2016 оны 02 дугаар сард 14 хоног, 03 дугаар сарын 15-аас 03 дугаар сарын 25-ны хороонд 10 хоногийн хугацаанд ерөнхий боловсролын “Орхон цогцолбор” сургууль, 7 дугаар сургууль, “Наран цогцолбор” сургуулиудын 2-5 дугаар ангийн сурагчдын дунд “Ногоон гэрэл-цагаан шугам” тэмцээнийг, сургуулийн өмнөх насны цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд “Замын хөдөлгөөний дүрмийн цагаан толгой” сэдэвт арга хэмжээг тус тус зохион явуулж, 10 баг оролцсоноос 4 дүгээр цэцэрлэгийн баг тэргүүн | 90% | 4,5 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | байранд орсон. Үүнд шаардагдах 1.5 сая төгрөгийн төсвийг аймгийн Засаг даргын хөрөнгөнөөс гаргуулан, тэмцээнийг амжилттай зохион явуулсан.<br>Цагдаагийн газрын 40 жилийн ойн ажлын хүрээнд тус газрын үйл ажиллагааг иргэдэд сурталчилах зорилгоор хэсгийн байцаагчийн ажлын нэг өдрийн талаар “Тусгал” телевизтэй хамтран хэсгийн байцаагч, цагдаагийн дэслэгч Э.Цогтсайханы ажлын нэг өдрийн талаар нэвтрүүлэг бэлтгэн явуулсан бөгөөд үүнд шаардагдах 250.000 мянган төгрөгийн хөрөнгийг аймгийн Засаг даргын хөрөнгөөр зохион явуулсан.<br>Цагдаагийн газраас аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд 2017 онд ажиллах Олон нийтийн цагдаагийн ажилтны хөдөлмөр аюулгүй байдлын тусгай хувцас, цалин урамшуулал, сургалтын зардалд 164 сая 248.000 мянган төгрөгийг төсөвт суулгуулж ажилласан. | | |
| 42 | 6.1.5. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран сэрэмжлүүлэг, нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэж, иргэд, олон нийтэд хүргэх. | 2016 оны 06 дугаар сарын 03-ны өдөр үйлдвэрлэлийн болон хамгаалалтын бүсэд ойрхон зусахаар буусан 12 малчин өрхөд учирч болзошгүй хохирлоос урьдчилан сэргийлж, малаа хамгаалалтын хориотой бүс рүү бэлчээхгүй байх талаар албан мэдэгдэл өгч ажиллалаа.<br>2016 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр Олон нийттэй харилцах албаны ахлах байцаагч, цагдаагийн хошууч Т.Хатанбаатар үйлдвэрийн Олон нийттэй харилцах албаны “Эрдэнэт-ТВ” телевизийн “Зочины цаг” нэвтрүүлэгт оролцож, тасгаас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр явуулж байгаа үйл ажиллагаа, холбогдох хууль, журмын талаар ярилцлага өгч, байгууллагын өмч хөрөнгийг болон иргэд, ажилчид өмч хөрөнгө, эд зүйлээ гэмт халдлагаас хэрхэн сэргийлж, Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах талаар зөвлөмж нэвтрүүлж ажилласан.<br>Үйлдвэрийн дүүргийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал, эргүүл шалгалтаар илрүүлэн, хянан шалгаж байгаа хэрэг, зөрчлийн талаарх товч мэдээллийг үйлдвэрийн Олон нийттэй харилцах албанд долоо хоног бүрийн даваа гаригт хүргүүлж, радио, телевизийн мэдээллээр нийтэд хүргэн ажиллаж байгаа бөгөөд нийт 49 мэдээллийг хүргүүлээд байна.<br>Баян-Өндөр сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн хурлаар 2016 онд хийж гүйцэтгэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын салбар төлөвлөгөөг гарган хэлэлцэж, 2016 оныг “Нохойг эзэнжүүлж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх жил” болгон зарлаж, нохойд уруулж гэмтсэн, хазуулсан Цагдаагийн газарт бүртгэгдсэн гэмт хэргийн талаар мэдээлэл оруулан хэлэлцүүлж, аймгийн 22 багийн Засаг дарга нарт Эрүүгийн хуулийн 201 дүгээр зүйл | 90% | 4,5 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | буюу “Орчиндоо аюул учруулах амьтныг зохих хамгаалалтгүй байлгах” гэмт хэргийн талаар сургалт зохион байгуулан, иргэдэд энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор сэрэмжлүүлэг тарааж, www.police.or.gov.mn цахим хуудас болон facebook хаягаар сурталчилан ажилласан.<br>“Цагаан сар”, “Мартын-8”, “Монгол цэргийн баяр” çýðýã áàÿðûí ¿åýð багийн хэсгийн байцаагч, багийн цагдаа, Олон нийтийн цагдаагийн ажилтан нарын хамт эргүүл шалгалтыг эрчимжүүлэн, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж, ñýðэì æë¿¿ëýã õóóäàñ 280 øèðõýãèéã òàðààí , 255 èðãýíä çº âëºãºº ºãñºí байна.<br>Тус газрын Íèéòèéí хýâ жóðàì хàìãààëàõ òàñãààñ ãýì ò õýðýã, çº ð÷ëºº ñ óðüä÷èëàí ñýðãèéëýõ çîðèëãîîð Цагаан сарын баярын өдрүүдэд аж ахуйн нэгж, байгууллагуудад 385 àëáàí ì ýäýãäýë õ¿ðã¿¿ëж, хариуг àâ÷, ¿ð ä¿í ã тооцож ажилласан.<br>“Эрдэнэт үйлдвэр” ХХК дахь Гэрээт цагдаагийн хэлтсээс ãýì ò õýðãýýñ óðüä÷èëàí ñýðãèéëýõ ÷èãëýëýýð 8 àæ àõóéí íýãæ, áàéãóóëëàãûí 196 õ¿íä ãýì ò õýðãýýñ óðüä÷èëàí ñýðãèéëýõ ÷èãëýëýýð ÿðèà õèéñýí . Гэмт хэрэг, зөрчил, болзошгүй үйлдвэрлэлийн осол, гамшгаас урьдчилан сэргийлэх, хамтран ажиллах талаарх сэрэмжлүүлгийг үйлдвэрийн 10 цех хэлтсийн 481 ажилчдад тарааж ажилласан.<br>Аймгийн хэмжээнд үйлдэгдэж байгаа өсөлттэй гэмт хэргийг бууруулах ялангуяа гудамж талбайд үйлдэгдэж байгаа ãýì ò õýðãèéã áóóðóóëàõ, óðüä÷èëàí ñýðãèéëýõ çîðèëãîîð îðîí íóòãèéí “Номин” телевизтэй хамтран шууд нэвтрүүлгүүдийг зохион явуулж, “Дуудлага” íýâòð¿¿ëãийг сард 2 удаа нийт 12 удаа çîõèîí ÿâóóëсан.<br>Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа болон алба хаагчтай холбоотой санал, хүсэлт, гэмт хэрэг, зөрчлийн мэдээ, мэдээлэл хүлээн авах, иргэд олон нийтэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Цагдаагийн газрын ил тод байдлыг хангах зорилгоор байгууллагын цахим хаяг www.orkhon.police.gov.mn, www.facebook.com/ Орхон_Аймгийн_Цагдаагийн_Газар, www.twitter.com /Orkhon_Police цахим хуудсуудыг нэвтрүүлэн ажиллаж байна.<br>2016 оны 02 дугаар сард Баян-Өндөр сумын Баянцагаан багийн хэсгийн байцаагч болон багийн Засаг даргын ажлын алба аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс зарласан гурвалсан гэрээг дүгнэхэд тэргүүн байр эзлэн 3 сая төгрөгөөр шагнуулсаныг хэвлэл мэдээллийн байгууллага болон бусад багуудад туршлага судлах зорилгоор сурталчилан ажилласан.<br>Гэмт хэрэг, зөрчлийн талаар 7 хоног бүрийн Мягмар гарагт, сар бүрийн эхний 7 хоногт орон нутгийн 8 телевизээр нөхцөл байдлын талаар мэдээлэл хийн, гэмт хэрэг ихээр үйлдэгдэж байгаа баг, аж ахуйн | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | нэгж, байгууллагын захирал, эздэд мэдэгдэл хүргүүлэн, хийсэн ажлыг газар дээр нь шалгаж, үр дүнг тооцон ажиллаж байна.<br>Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн зүйн хэлтэстэй хамтран орон нутгийн “Номин”, “Тусгал”, “ТВ-10” зэрэг телевиз, “Нар туссан цаг” сонин, 4 фм радиотой хамтран сард 1 удаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нэвтрүүлэг бэлтгэн явуулж байна.<br>Зам тээврийн хэрэг, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр орон нутгийн “Номин”, “ТВ-10”, “MBS”, “ETV”, “Эрдэнэт ТВ”, “Тусгал”, “Мэдээллийн бирж” телевизүүдээр 46 удаа, нийт 138 удаагийн давтамжтайгаар мэдээлэл, сэрэмжлүүлэг хийж ажилласан. Мөн 7 хоног бүрийн 5 дахь өдөр бүр тасгийн хэмжээнд нэгдсэн хяналт шалгалтыг хийж, “Номин” телевизтэй хамтран “Дуудлага” нэвтрүүлгийг нийт 4 удаа зохион явуулсан. | | |
| | 43 | 6.1.9. Орон нутгийн төсөв санхүүжилтээр тус аймгийн төв болон хөрш зэргэлдээ аймаг хоорондын хатуу хучилттай авто замуудыг /тээврийн хэрэгслийн улсын дугаар илрүүлэгч/ камержуулах. | 2016 онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар 400 сая төгрөгийн өртөг бүхий хяналтын камерын өргөтгөлийн ажлын хүрээнд гудамж тайлбайд 60 камер, аймаг улсын чанартай хатуу хучилттай авто замын Улаанбаатар, Дархан-<br>Уул, Сэлэнгэ аймгуудын чиглэлээс Орхон аймаг руу орох замд байрлах 165 дугаар<br>хаалттай гарам болон Орхон аймгаас Булган аймгийн чиглэлд гарах пост онд тээврийн хэрэгслийн улсын дугаар таних тусгай 2 камеруудыг тус тус суурилуулан хүлээн авсан болно. | 100% | 5 |
| | 44 | 6.1.10. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль “Бэлэн бус хэлбэрээр торгууль оногдуулах журам”-ыг хэрэгжүүлэх зорилгоор аймаг орон нутгийн төсөв санхүүжилтээр цагдаагийн шалгах төхөөрөмжөөр алба хаагчдыг хангах ажлыг зохион байгуулах. | Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, зөрчил гаргасан этгээдэд ногдуулах торгуулийг бэлэн бус хэлбэрээр ногдуулах зүйл заалт шинээр орсон тул алба хаагчийн ажиллах боломжийг бүрдүүлэх зорилгоор үйлдвэрийн удирдлагад хүсэлт тавьж, хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлж, Солонгос улсад үйлдвэрлэсэн “Мз” загварын сүлжээнд ажиллах машин, “Bixolon” загварын хэвлэгч машин тус бүр хоёрыг авч сүлжээнд холбуулан, үйл ажиллагаандаа хэрэглэхээс гадна алба хаагчийн ажиллах нөхцөлийг дээшлүүлэх, эргүүл, хяналт шалгалтын үед илрүүлсэн зөрчлийн үйл явдлыг бэхжүүлэн бичих, баримтанд үндэслэн асуудлыг шийдвэрлэхэд ашиглах энгэрийн камер хоёрыг авч олгосон. | 100% | 5 |

БИЕЛЭЛТ

| д/д | Õýðýãæ¿¿ëýõ çî ðèëòûí òîî | Áèåëýëò | | | | | Ã¿éöýòãýëийн хувь | Øàëãóóð ¿ç¿¿ëýëòèéí áèåëýëòèéí äóíäàæ оноо | Õýðýãæèëò óäààø ðàëòàé áîë ø àëòãààí |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 0-59 | 60-69 | 70-79 | 80-89 | 90-100 | | | |
| **1** | **44** | | **1** | | **4** | **39** | **92.5** | **4,6** | 3.2.5. Нутаг дэвсгэрийн төр захиргаа, хууль хяналтын байгууллагатай хамтран мал хулгайлах болон анхаарал татсан зарим төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр бүсчилсэн сургалт, зөвлөгөөниig зохион байгуулах гэсэн заалт хөрөнгө санхүүгийн шалтгаанаар бүрэн биелээгүй, 60 оноогоор дүгнэгдсэн болно. |

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
ТӨЛӨВЛӨЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАСГИЙН ДАРГА,
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА Д.МӨНХБАТ

ХЯНАСАН:
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГА
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Д.ЭНХБАЯР